

# ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ДӨЧИН ТАВДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН





# ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДӨЧИН ТАВДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТ

---

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааг Монголын Криминологичдын Холбооны Ерөнхийлөгч Г.Эрдэнэбат удирдаж, Тээврийн прокурорын газрын орлогч прокурор Х.Батчимэг, ЦЕГ-ын ахлах мэргэжилтэн С.Энхбаатар, тус холбооны судлаач Н.Туяа, Г.Оюунболд, О.Мөнхцэцэг, Э.Ганцэцэг, Б.Ариунтуяа нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ.

Улаанбаатар хот  
2021 он

ННА 67.408  
ДАА 345  
Э-807



## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДӨЧИН ТАВДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТ

### СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааг Монголын Криминологичдын Холбооны Ерөнхийлөгч Г.Эрдэнэбат удирдаж, Тээврийн прокурорын газрын орлогч прокурор Х.Батчимэг, ЦЕГ-ын ахлах мэргэжилтэн С.Энхбаатар, тус холбооны судлаач Н.Туяа, Г.Оюунболд, О.Мөнхцэцэг, Э.Ганцэцэг, Б.Ариунтуяа нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ.

ISBN: 978-9919-9742-7-5

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-76113207  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

# Гарчиг

ӨМНӨХ ҮГ .....	5
ӨМНӨТГӨЛ .....	7
ШҮҮМЖ .....	9
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	11

## Нэг. УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын үндэслэл, шаардлага .....	12
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт .....	13
1.3. Судалгааны хамрах хүрээ, арга зүй .....	14
1.4. Судлагдсан байдлын тойм .....	15

## Хоёр. СУДАЛГААНЫ ДҮН

2.1. Эрх зүйн орчин .....	16
2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ .....	26
2.3. Иргэний хэргийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ .....	50
2.4. Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт .....	73

ДҮГНЭЛТ .....	86
САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	90
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ .....	92

# ХҮСНЭГТ, ГРАФИК, БУДУУВЧИЙН ЖАГСААЛТ

## Хүснэгт

Хүснэгт 1. Ярилцлагын судалгаанд оролцогчид	14
Хүснэгт 2. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн үзүүлэлт	27
Хүснэгт 3. ЭХХШТХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн харьцуулалт	29
Хүснэгт 4. Таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдал	30
Хүснэгт 5. Таслан сэргийлэх зарим арга хэмжээний тоон үзүүлэлт	31
Хүснэгт 6. Таслан сэргийлэх зарим арга хэмжээний талаарх тоон үзүүлэлт	32
Хүснэгт 7. Сэжигтнийг баривчлах арга хэмжээний тоон мэдээ (шүүхийн зөвшөөрлөөр)	34
Хүснэгт 8. ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн)	35
Хүснэгт 9. Цагдан хорих ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн)	35
Хүснэгт 10. ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн зөвшөөрлөөр)	38
Хүснэгт 11. Цагаатгасан хэргийн тоон мэдээ	41
Хүснэгт 12. УДШ-ээс цагаатгасан хэргийн тоон мэдээ	42
Хүснэгт 13. Хэрэгсэхгүй болгосон хэрэг (прокурорын байгууллагын мэдээ)	44
Хүснэгт 14. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэрэг	45
Хүснэгт 15. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэргийн үндэслэл	46
Хүснэгт 16. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шийдвэрлэлт	49

## График

График 1. Мөрдөн байцаалтын хэрэг, яллагдагчаар татсан хүний тоо	43
График 2. Хэрэгсэхгүй болгосон хэрэг, яллагдагчийн тоо	43
График 3. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэрэг	44
График 4. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тоон мэдээ	49
График 5. Нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал	51
График 6. ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан хохирол барагдуулалт	57
График 7. Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг шийдвэрлэсэн байдал	65

## Бүдүүвч

Бүдүүвч 1. Мөрдөн байцаалт явуулах үндэслэл	27
Бүдүүвч 2. Судалгаа хийсэн дэс дараалал	28

## Өмнөх үг

**М**анай улсад 2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогчийг хамгаалах, хохирол барагдуулалтыг шинэ шатанд гаргах явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Нээлттэй Нийгэм Форум эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн энэхүү чухал зорилтын хэрэгжилтийг тал талаас нь нухацтай авч үзэж, судлах чиглэлээр анхааран ажиллаж байна.

Энэ удаа Монголын Криминологчдын Холбооны гүйцэтгэсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт” судалгааг уншигч Танд хүргэж байгаадаа баяртай байна. Тус судалгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг төлүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, энэ чиглэлээр нэхэмжлэх эрх үүсэж буй хэргийг тоймлож, мөн бусад улс орны зохицуулалтыг харьцуулж үзсэнээрээ ач холбогдолтой.

Энэ нь хохирол барагдуулах тогтолцоог үнэлэх чиглэлээр хийгдэж буй дөрөв дэх цуврал судалгаа бөгөөд цаашид ч энэ сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээг уншигчдад хүргэхээр ажиллаж байна. Иймээс бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 20 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид

дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлгийг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн видеог та бүхэн манай цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна. Үүний зэрэгцээ “Хохиролгүй барагдуулъя” цахим аян өрнүүлж, энэ чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүнг олон нийтэд таниулах, шийдэл санал болгох ажлыг санаачлан хэрэгжүүллээ.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

## Өмнөтгөл

**М**онгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй...", мөн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээн заасан. Тиймээс иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ төр хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

Эрх зүйт төр нь хууль дээдлэх, төр, иргэн харилцан үүрэг хүлээх, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хангах зэрэг үндсэн зарчмаар биеллээ олдог. Ийнхүү төр, иргэн харилцан үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага өндөрсөж, төрийн зүгээс иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах нь тулгамдсан асуудал болоод байна.

Өнөөдөр шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэд хохироход хохирлоо нөхөн төлүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй, шүүхийн практик нэг мөр тогтоогүй байгаа нь судалгаа хийх үндэслэл болсон юм. Энэхүү судалгаагаар эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, энэ төрлийн нэхэмжлэлийг шүүхээс хэрхэн шийдвэрлэж буйг тодорхойлохыг эрмэлзсэн болно.

Орчин үед эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга барил нь хуульч, хууль сахиулагчдад хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх, мэдлэг олгох, ур чадварыг нь сайжруулах явдал гэж үздэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа хууль тогтоомжид заасан



үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчигдсөн тохиолдолд түүнийг зөвтгөх арга хэмжээ авах нь хүний эрхийн гол баталгаа юм.

Хүний эрхийг хангах, эрүүдэн шүүлттэй тэмцэх чиглэлээр хуулийн хэрэгжилтэд хийж буй энэхүү судалгаа нь хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, прокурорын хяналт, шүүн таслах ажлын үр нөлөөг дээшлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Г.ЭРДЭНЭБАТ

## Шүүмж

**М**онголын Криминологичдын Холбооны судлаачдын багийн хийсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт” судалгааны тайланг анхааралтай уншиж танилцлаа. Криминологийн шинжлэх ухааны нэг үндсэн салбар болох виктимологийн өмнө тавигдах чухал зорилт бол гэмт хэргийн улмаас хохирох явдалд дүн шинжилгээ хийж, хохирох болсон шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, учир холбогдлыг нээн харуулах, дахин хохирохоос урьдчилан сэргийлэх арга зүй, арга, аргачлал боловсруулах, зөвлөмж гаргахад оршино.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах эрх зүйн зохицуулалт, хамгаалалт, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хохирлыг барагдуулах асуудлыг анх удаа бүрэн цогцоор нь судалсанд энэ судалгааны ач холбогдол оршиж байна. Энэ судалгаагаар эрүүгийн процессыг хэрэгжүүлэгчдийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо арилгуулах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх, үндэслэл, хохирлын төрлийг нарийвчлан судалсан нь олзуурхууштай.

Судалгаа хийхдээ аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид, бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан тоон болон чанарын судалгааны аргыг ашиглажээ. Судалгааны хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт, цагдаагийн байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна. Мөн тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой гомдол, мэдээлэлд холбогдох материал, Иргэний хэргийн материал, Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг судалж, өмгөөлөгч, мөрдөгч, прокуроруудтай фокус бүлгийн ярилцлага хийсэн байх бөгөөд харьцуулсан судалгааны хүрээнд гадаадын зарим улсын тухайн институцийн эрх зүйн зохицуулалт хамгаалалт, туршлагыг судалжээ.

Энэхүү судалгаа нь шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэд, хуулийн этгээд хохирох, хохирлоо нөхөн төлүүлэх ажиллагааны талаар нэг мөр ойлголт авч зөв хэрэглэхэд хувь нэмэр болно гэж үзэж байна. Түүнчлэн, шүүхийн нэгдсэн практик тогтоох, эрүүгийн процессын ажиллагааг гардан хэрэгжүүлэгчдэд хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх, мэдлэг олгох, ур чадварыг нь сайжруулах үндсэн дээр процессын эрх зүйн зарчмуудыг чанд сахих, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу явуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын хяналт, шүүн таслах ажлын үр нөлөөг дээшлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд онол, практикийн чухал ач холбогдолтой гэж дүгнэхэд хүргэж байна. Энэхүү судалгааны тайлан, үр дүн нь эрүүгийн процессыг хэрэгжүүлэгчдийн гарын авлага болох төдийгүй хууль зүйн салбарын эрдэмтэн, профессор, багш, оюутан, сонсогчид эрүүгийн процессын судлагдахууны хүрээнд ашиглах боломжтой гэж үзэж байна.

Энэ асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлахад дараах зөвлөмжийг өгч байна:

1. нэр томьёо, тодорхойлолт, ойлголтын талаар онол, арга зүйн шинжилгээг (*grounded theory*) нарийвчлан хийх (жишээ нь, хохирол, хор уршиг, гэм хор, хор аюул гэх нэр томьёог нарийвчлан судлах, тодорхой санал дэвшүүлэх, түүний дотор хохирлын төрөл, хохирлыг нөхөн төлөх, арилгах, нөхөн сэргээх, уучлалт гуйх хэлбэрүүд гэх мэт нэг мөр болоогүй ойлголтуудыг тодорхойлон нэг мөр ойлголт өгөх зэрэг);
2. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн орчинд контент-анализын аргын тусламжтайгаар мөрдөгч, прокурор, шүүгчдийн үйл ажиллагаа, нэр хүндийн талаар иргэд, хохирогчдын санаа бодлыг судлах;
3. Гадаад улс орнуудын хууль тогтоомж, практикийг судалж манай оронд ямар зохицуулалт, хэм хэмжээ, практик нутагшуулах талаар санал зөвлөмж гаргах нь зүйтэй.

Эдгээр нь тухайн судалгааны ажлын ерөнхий үнэлэмжид нөлөөлөхгүй бөгөөд зөвхөн зөвлөмжийн шинжтэй болно.

Шүүмж бичсэн:



Ч.Нямсүрэн  
Доктор (PhD), профессор

## Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УДШ	Улсын Дээд Шүүх
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ТББ	Төрийн бус байгууллага
ТСАХ	Таслан сэргийлэх арга хэмжээ
ТҮААҮ	Тодорхой үйл ажиллагаа, албан үүрэг

## Нэг. УДИРТГАЛ

**М**онгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заажээ.

Үндсэн хуулийн энэ зохицуулалтын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн баталж мөрдсөн бөгөөд уг хуулиар мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирол буюу хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, хилс ял шийтгүүлсэн буюу цагаадсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, хууль бусаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн, яллагдагчийг эрүүдэн шүүсэн тохиолдолд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг зохицуулж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан байна.

### 1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд хохирол учирч, түүнийг шийдвэрлэхгүй байх, мөн нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие махбодын хувьд ахин хохирч үлдэж байгаа талаар тодорхой судалгааны

тайлан, зөвлөмжүүдэд<sup>1</sup> дурдсан байх бөгөөд дээрх асуудал нь урт хугацаанд шийдвэрлэгдээгүйгээс ужгирсан шинжтэй болсон<sup>2</sup> гэж дүгнэсэн байна. Иймд ЭХХШТХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш тус хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох нь ач холбогдолтой гэж үзсэн.

## 1.2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад эрх бүхий албан тушаалтан, хуульчийн хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийн улмаас бусдад учирсан хөрөнгийн хохирол болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг тооцож нөхөн төлүүлэх талаар зохицуулсан ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлах зорилгыг дэвшүүлсэн болно. Судалгааны зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон хүн, хуулийн этгээдтэй холбоотой тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
2. Энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг судлах, гэм буруутай албан тушаалтнуудад хүлээлгэж байгаа хариуцлагын талаар судлах;<sup>3</sup>
3. Эрүүгийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, бусад байдлаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх (сүүлийн 3 жилээр);

<sup>1</sup> НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), 2014 оны 9 дүгээр сар, Хүний эрхийн Үндэсний Комиссын 2019 оны тайлангийн хэсэг “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилт”.

<sup>2</sup> УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс хамтарсан “Эрүүдэн шүүхийн хохирогчдын эрхийн асуудал” хэлэлцүүлгийн танилцуулга, протокол, 2020.

<sup>3</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхэд нэхэмжлэл гаргахаар зохицуулсан.

4. Гадаадын зарим орны хууль тогтоомжид эрүүгийн процессын явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах талаар зохицуулсан байдлыг харьцуулан судлах;
5. ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангах талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

### 1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 он хүртэлх хугацаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийн төлөв байдлыг тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан судлав.

Судалгааны хүрээнд ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийг үнэлэхийн тулд цагдаагийн байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв. ЭХХШтХ үйлчилж эхэлснээс хойш цагдаа, прокурор, шүүхийн захиргааны байгууллага мэдээллийн сангаа шинэчилсэн бөгөөд тухайн байгууллагын баталсан загвар, аргачлалын дагуу гаргасан тоон мэдээг шинжиллээ.

Судалгааны зорилгын хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль бусаар эрх нь зөрчигдсөнтэй холбоотойгоор 2017 онд шийдвэрлэсэн 9, 2018 онд шийдвэрлэсэн 10, 2019 онд шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн найман шийдвэрт (Шүүхийн цахим санд байршуулсан) дүн шинжилгээ хийж, шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нийт 40 хуульчийн дунд санал асуулгын аргаар судалгаа явуулж дүгнэв.

#### *Хүснэгт 1. Ярилцлагын судалгаанд оролцогчид*

Ажилласан жил	Прокурор	Шүүгч	Мөрдөгч	Өмгөөлөгч
1 жил хүртэл	-	-	-	3 (30%)
2-4 жил	-	4 (40%)	5 (50%)	3 (30%)
5-аас дээш жил	10 (100%)	6 (60%)	5 (50%)	4 (40%)

## 1.4. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Хууль зүйн үндэсний хүрээлэн “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох нь” судалгааны ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар 2009 онд хийсэн бөгөөд эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж гаргаж, сэтгэл санааны хохирлыг үнэлэх аргачлалыг санал болгожээ. Тухайн судалгаагаар дэвшүүлсэн асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан хэдий ч сэтгэл санааны хохирлыг үнэлэх аргачлал, Иргэний хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг шийдвэрлээгүй өдийг хүрчээ.

Түүнчлэн 2019-2020 онд Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар судлаач М.Ванчигмаа “Эдийн бус гэм хорыг хянан шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, судлаач А.Түвшинтөгс нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, харьцуулсан дүн шинжилгээ” сэдвээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийжээ. Дээрх судалгаануудыг харьцуулан үзвэл Иргэний хуульд эдийн бус гэм хорын талаар зохицуулсан хэм хэмжээний хийдэл, шүүхийн практикийн учир дутагдалтай талыг нээн илрүүлснээрээ зарим талаар ижил дүгнэлтэд хүрчээ.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК)-оос гаргадаг Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд (2019 он) “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах талаар хуульчилсан ч шүүх бүрэн ашиглахгүй байна” гэж дүгнэжээ.<sup>4</sup>

<sup>4</sup> <http://nhrcm.gov.mn>



## Хоёр. СУДАЛГААНЫ ДҮН

### 2.1. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

#### 2.1.1 Олон улсын эрх зүйн зохицуулалт

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлд “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй” гэж заажээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд “Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй” гэж, мөн 14 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол, тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж заасан байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3-т “Төрийн албан тушаалтан

болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” гэж тус тус зохицуулжээ.

### 2.1.2. Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заасан нь бусдын хууль бусаар учруулсан хохирол буюу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг тунхаглаж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан нь чухал бөгөөд дэвшилттэй зохицуулалт болжээ.

Үндсэн хуулийн энэ заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж хязгаарлаагүй тул энэ нь хохирсон этгээдэд өөрт учирсан эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан дэвшилттэй зохицуулалт болсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зорилгоор 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус шинэчлэн баталж мөрдсөн бөгөөд эдгээр хуулиар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, мөрдөгч, прокурор шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг арилгах асуудлыг хуульчилсан.

### 2.1.3. Хууль тогтоомж, түүхэн уламжлал

- ♦ **Монгол Улсын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль**<sup>5</sup>

Тус хууль нь иргэнийг эрүүгийн хариуцлагад хууль бусаар татан, мөрдөн мөшгөж, хилсээр хорьж цагдсаны төлөө төр хариуцлага хүлээх асуудлыг ямар нэг хэмжээнд зохицуулсан анхны хууль юм. Энэ хуулийг мөрдлөг болгохоос өмнө БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 онд нууц тогтоолоор баталсан журам үйлчилж байжээ. Уг хуулиар иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулсныг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагаа гэж үзэж, түүний улмаас учирсан хохирлыг иргэн арилгуулах эрхтэй болохыг тогтоосон байна. Гэвч энэхүү хуульд зааснаар хохирсон иргэн эдийн хохирол буюу аваагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болон эд хөрөнгийн бусад хохирлыг гаргуулах боломжтой өөрөөр хэлбэл, уг хуулиар иргэнд учирсан эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх тухай зохицуулаагүй байна.

- ♦ **Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль**<sup>6</sup>

Тус хуулиар хилс хэрэгт шийтгүүлсэн хэлмэгдэгчид нөхөн олговор олгохоор зааж, цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 1,000,000, бусад хэлмэгдэгчид 500,000 төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор тус тус олгохоор шийдвэрлэжээ.

<sup>5</sup> 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталж, 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хүчингүй болсон.

<sup>6</sup> 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр баталсан.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүмүүс энэ хуулийн дагуу нөхөн олговор авч байгаа мэт боловч хэлмэгдэгчдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлын хэмжээг дээрх хуулиар тогтоосон нөхөн олговрын хэмжээтэй зүйрлэхийн аргагүй, тэгээд ч хилс хэрэгт шийтгүүлж цаазаар авхуулсан, хоригдон мөрдөгдөж, ялаа эдэлж байхдаа нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд учруулсан гэмтэл согог болон сэтгэл санааны шаналалд үнэлэмж тогтоох гэсэн оролдлогыг төр хийгээгүй болох нь хуулиас харагдаж байна. Иймд энэхүү хуулийг Монголын түүхийн нэгэн эмгэнэлт цаг үед хилс хэрэгт шийтгүүлж, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч хэлмэгдсэн хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах гэхээсээ илүүтэй нэгэн цагт иргэдийнхээ эсрэг хоморголон үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө төр уучлал эрж, энэ мэт бусармаг үйл ажиллагаа түүхэнд дахин давтагдан гарахгүй байх нийгэм, улс төр, хууль зүйн дархлаа бий болгох зорилготой зохицуулалт гэж дүгнэж байна.

#### ◆ Эрүүгийн байцаан шийтгэх хууль

Улсын Их Хурал (УИХ)-аас 2002 онд батлан мөрдүүлсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ)-ийн<sup>7</sup> 44 дүгээр бүлэгт “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” тухай зохицуулсан бөгөөд мөн хуулийн 388 дугаар зүйлд “...иргэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан..., сэтгэл санааны үр дагавраа арилгуулах... эрхтэй” гэж заасан ба мөн хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-д зааснаар:

- Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.
- Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно.

<sup>7</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан.

- Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах ажээ.

Өөрөөр хэлбэл, ЭБШХ-д эдийн бус хохирол буюу сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрх болон шаардлага гаргах үндэслэлийг заасан боловч хохирлын хэмжээг тогтоох болон нөхөн төлөх журмыг Иргэний хуулиар зохицуулахаар үлдээжээ.

#### ◆ **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**

УИХ-аас 2017 онд батлан мөрдүүлсэн ЭХХШТХ-ийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй”, 45.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэж тус тус зохицуулсан. Энэ бүлэгт заасан хохирол нөхөн төлүүлэх эрх дараах тохиолдолд үүсэхээр заажээ.<sup>8</sup> Үүнд:

1. Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон;
2. Тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан;
3. Тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;
4. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон;
5. Яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.

<sup>8</sup> ЭХХШТХ-ийн 45.2 дугаар зүйл.

Мөн хуулийн 45.4-т зааснаар эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй байна. Тус хуулийн 45 дугаар бүлэгт 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтийг судалгааны тайлангийн 2.2 дугаар хэсэгт тодорхой дурдах болно.

#### ◆ **Иргэний хууль тогтоомж, түүнд хамаарах тайлбар**

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэйд үндэслэн гэм хорыг нэхэмжилсэн хэргийг нэхэмжлэлээр бус харин хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дахь хэсэгт зааснаар онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцож болдгоос гадна мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт зааснаар прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцдог. Дээрх зохицуулалтын дагуу прокурор нь тухайн төрлийн хэрэгт гуравдагч этгээдээр эсхүл төрийг төлөөлж эсхүл аль алианаар нь оролцох боломжтойг нэхэмжлэгч талд ойлгомжтой, эрх зүйн үндэслэл бүхий дурдсан байх ёстой.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт заасан "...хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг

хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй” гэснийг мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр төлүүлэх “тусгайлан заасан тохиолдол” гэж шууд дүгнэх боломжгүй юм. Монгол Улсын Дээд Шүүхийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай” 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 3 дугаар тогтоолд “нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн” талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг ихэнхдээ мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд дээрх үндэслэлээр хохирогчоор тогтоогдсон этгээд эд материалын хохирол хүлээснээ үндэслэл бүхий нотлох баримтаар нотолж хохирлын тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг ердийн журмаар хянан шийдвэрлэх үүрэгтэй”<sup>9</sup> хэмээн тайлбарласан байдаг нь хохирлоо нэхэмжлэх, түүнийг шүүх хянан шийдвэрлэх боломж олгосон.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолд<sup>10</sup> “Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйгээр учруулсан гэм хорыг ойлгоно”, түүнчлэн “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэргийг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж тус тус тайлбарласан байдаг ба дээрх хууль хэрэглээний зөвлөмжийн дагуу шүүх хуулийг хэрэглэж ирсэн. Дээрх тайлбар, хэрэглээний зөвлөмжөөс үзэхэд эдийн бус гэм хорыг Иргэний хуулийн 497.1 дэх зохицуулалтаар хязгаарлан ойлгож байна.

<sup>9</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхэтгэл I, УБ., 2001, 205 дахь тал.

<sup>10</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”, Дугаар 15.

Харин “Бусдын эрх” хэмээх ойлголтод бусад хуулиар тогтоосон эдийн бус гэм хорыг арилгах боломжийг багтаасан эсэх нь тодорхойгүй тул шүүх тус заалтыг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, шүүх системчлэн тайлбарлах аргыг ашиглан Эрүүгийн хуулийн 45.1, 45.4 дэх заалтын дагуу хууль бусаар цагдан хоригдсон этгээдийн сэтгэл санааны гэм хорыг арилгах шийдвэр гаргах бүрэн боломжтой.

Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2-т зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой юм. Дээрх зохицуулалтуудаас үзэхэд Иргэний хуульд бусдын бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсны улмаас бий болох сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах талаар тусгаагүй ч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын улмаас сэтгэл санаанд хохирол бий болсон бол мөнгөн хэлбэрээр нэхэмжлэх боломжийг хуульд тодорхой зааж өгсөн. Гэхдээ Иргэний хэргийн шүүх Иргэний хуулийн 230 дугаар зүйлийг үндэслэж сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахгүй байх практик сүүлийн үед тогтжээ. Шүүх Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасны дагуу сэтгэл санааны хохирлыг гаргуулахаар тусгайлан заагаагүй гэх тайлбар хийн, шийдвэрлэж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 18 болон 52 дугаар бүлгийн зохицуулалтаас харахад логикийн хувьд гэм хорыг эдийн болон эдийн бус гэм хор гэж ангилж үзэхээр байна. Түүнчлэн 497 дугаар зүйлд “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” болохыг хуульчлан зохицуулж өгчээ. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт “Хохирогч нас барсан бол... гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй”, 508 дугаар зүйлийн 508.2 дугаар хэсэгт “Гэм хор учруулсны төлбөрийг...-ийн аль нэг нь авах эрхтэй” гэж тус тус заасныг үзвэл гэм хор гэдэг ойлголт нь дотроо эдийн болон эдийн бус гэм хорыг багтааж байгаа гэсэн утгаараа эдийн бус гэм хорыг 497 дугаар зүйлд заасан аль ч тохиолдолд хамаатай байж болох мэт боловч 505 дугаар зүйлийн 505.1 дүгээр хэсэг болон 508 дугаар зүйлийн 508.3 дугаар хэсэгт заасан гэм хорыг



арилгах төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалаас харахад эдийн бус гэм хорыг хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой тусгаагүй нь тодорхой болж байна. Харин Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорыг арилгах тухай ойлголтыг нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой тусгаж өгсөн, мөн хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дугаар хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэсэн хязгаарлалт оруулснаараа хууль тогтоогч гэм хорын үүргийн харилцаанд эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтыг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд л үйлчлэхээр хуульчилсан нь харагдаж байна. Тиймээс хуулиар эдийн бус гэм хорын ойлголт болон түүнийг арилгах тухай нарийвчлан зохицуулаагүй, эдийн бус гэм хорыг үнэлэх нэгдсэн аргачлал байхгүй байгаа зэргээс үүдэлтэйгээр иргэн зөрчигдсөн эрхээ бүрэн сэргээлгэх эрх зүйн орчин хангалтгүй байна.

#### ◆ **Засгийн газрын тусгай сангийн тухай хууль**

Өмнө нь үйлчилж байсан 2006 оны Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Засгийн газрын нөөц сангийн 8.3.7-д заасан (байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт болон цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал) зардлаас шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байжээ. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2019 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зориулалтыг зааж, Эрүүгийн хуульд заасан 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор зохицуулсан. Гэвч тус сангаас эмчилгээний болон оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг л олгохоор заасан нь гэмт хэргийн хохирогчийн хохирлыг хангалттай хэмжээнд, шударгаар нөхөн барагдуулах зарчимд бүрэн нийцээгүй гэж дүгнэж болох юм. ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан хохирол нөхөн төлүүлэх үндэслэлээр эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч тус сангаас хохирлоо барагдуулах боломжтой.

**◆ Хууль хэрэгжүүлэгчийн мэдлэг, хандлага**

Судалгааны ажлын хүрээнд хууль хэрэгжүүлэгч буюу мөрдөгч, прокурор, шүүгчдийн дунд явуулсан санал асуулгын дүнг нэгтгэж үзэхэд ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан нэр томьёо, ухагдахуун, хууль зүйн фактын талаар зөрүүтэй ойлголттой байгаа ба өөр өөрсдийнхөөрөө ойлгон тайлбарлаж байгаа нь ажиглагдсан. Тухайлбал, мөрдөгч, прокуророос ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийг хэрэглэхэд ямар эх сурвалжуудыг мэдэх шаардлагатай болохыг асуухад хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдол бүрийг хууль бусд тооцдог шүүхийн байр суурьтай санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн.

Түүнчлэн ЭХХШТХ-ийн 45.2.4-т заасан “эрх бүхий албан тушаалтан”-д хэнийг хамруулан ойлгох талаарх асуулгад оролцогчид маш ерөнхий хариулт өгч, ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн гарчигт дурдсан албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтанд хамааруулна гэж хариулжээ. ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийг хэрэгжүүлэхэд мөрдөгч, прокурор ямар нэг үүрэг хүлээдэг эсэх талаарх асуултад мөрдөгчдийн 30 хувь мэдэхгүй, прокуроруудын 50 хувь нь хууль хэрэглээний зөрүүтэй байдлаас болоод хуулийн зүйл, хэсгийг хэрэгжүүлэх талаар идэвхтэй ажилладаггүй гэсэн байна. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн үндэс нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан гэм хорыг арилгахад чиглэсэн тул мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан бол үүнд хамаарахгүй гэж үзэх хандлагатай байна. Тиймээс “хууль зөрчсөн” хэмээх нэр томьёог эргэж харах нь зүйтэй. Хууль хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар энэхүү судалгааны “Иргэний журмаар гаргасан нэхэмжлэл, түүний шийдвэрлэлт” гэсэн дэд бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

## 2.2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2.2.1 Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл ба гэмт хэргийн нөхцөл байдал


Монгол Улсад 2017 онд 32,259 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 5,092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн дүнтэй гарчээ. Тухайн үед хийсэн судалгаагаар<sup>11</sup> нийт өссөн 5,092 хэргийн 60 хувь нь шинэ Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой, 35 хувь нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл шалгах ажиллагаа “хэрэг бүртгэлт” гэдэг ойлголтод тооцогдсон, мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай ойлголт шинэ хуулиар өөрчлөгдөж, хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах гэсэн хоёр өөр шийдвэр гаргах болсонтой холбоотойгоор гэмт хэргийн статистик үзүүлэлт өсжээ.<sup>12</sup>

ЭХХШТХ-ийн 31.1 дүгээр зүйлийн 1-д “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ” гэж тодорхойлсон. Мөн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолын бүтэц, агуулга, мөн чанарыг хуульд тусгайлан заасан нь аливаа гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг үндэслэл баримтгүйгээр хууль ёсны эрх ашиг, сонирхлыг нь зөрчигдөхөөс хамгаалах нөхцөл бүрдүүлжээ.

<sup>11</sup> ГХУСАЗЗ, “Гэмт хэргийн цагаан ном-2017” судалгааны тайлангийн үндсэн хэсэг.

<sup>12</sup> “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” судалгааны тайлангаас, ХСИС, 2012.

## Бүдүүвч 1. Мөрдөн байцаалт явуулах үндэслэл



Иймд энэхүү судалгааны ажилд хамаарах тоон мэдээ нь мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны явцад гаргасан үзүүлэлт, шийдвэрээр хэмжигдэхээр байна. Прокурор, цагдаагийн байгууллагын гэмт хэргийн тоон мэдээ зөрүүтэй гарч байгаа нь гэмт хэргийн талаарх тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал өөр өөр байдагтай холбоотой.

## Хүснэгт 2. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн үзүүлэлт

2017 онд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	ЭХХШТХ-ийн 30.15-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар	5,395
	ЭХХШТХ-ийн 30.17-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар	1,278
Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг		8,864


Тухайлбал, цагдаагийн байгууллагын 2017 оны гэмт хэргийн талаарх тоон мэдээнээс харвал илэрсэн гэмт хэрэг 8,856 байгаа бол прокурорын цахим

бүртгэлээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн тоо 8,864 буюу 8 хэргээр зөрүүтэй байна. Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2016, 2017, 2018 тайлангуудаас үзвэл сүүлийн гурван жилийн дунджаар жилд 34 мянган гэмт хэрэг бүртгэгдэж 8,400 орчим хэрэгт хүнийг эрүүгийн хэрэгт яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулж байна.

Судалгааны хүрээнд хохирол нөхөн төлүүлэх эрх үүсэхээр байгаа, ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан дараах тохиолдлын тоон үзүүлэлтийг боломжит бүхий л арга хэлбэрээр гаргахыг эрмэлзлээ. Үүнд:

1. Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсонтой холбоотой тоон мэдээ;
2. Тодорхой хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэрийн тоон мэдээ;
3. Тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосонтой холбоотой тоон мэдээ;
4. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон;
5. Яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон тоон мэдээ.

### *Бүдүүвч 2. Судалгаа хийсэн дэс дараалал*



Судалгааны хүрээнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол байгаа эсэхийг судлахад холбогдох эрх бүхий байгууллагаас дээрх тохиолдол гараагүй гэж мэдээлсэн тул бусад дөрвөн тохиолдлыг авч үзлээ.

## 2.2.2. Цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэнтэй холбоотой тоон мэдээ

Дээрх тоон мэдээнд дүн шинжилгээ хийхэд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 оны 2 дугаар сарын 24-ний хооронд, түүнээс хойш гэж дүгнэх шаардлага гарсан бөгөөд ЭХХШТХ-д 2020 онд орсон нэмэлт, өөрчлөлтийг ялган дүгнэв. 2020 оны нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох хүртэл хууль бусаар авсан бүх таслан сэргийлэх арга хэмжээний хохирогчид иргэний журмаар нэхэмжлэл гаргах боломжтой байсан. Үүний зэрэгцээ хувийн баталгаа, эрх хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ авснаас учирсан хохирол, эрх нь зөрчигдсөнөөс үүссэн үр дагаврыг нэхэмжлэх тохиолдол ч гарч байсан ажээ.

### Хүснэгт 3. ЭХХШТХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн харьцуулалт

<b>ЭХХШТХ (2017 оны шинэчилсэн найруулга)</b>	<b>ЭХХШТХ (2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт)</b>
<b>ЭХХШТХ-ийн 45.2 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл</b>	
2.2. хууль бусаар баривчилсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь тогтоогдсон эсхүл баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийг хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгосон.	2.1. хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон.

Хүнийг баривчлах, цагдан хорих болон тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэхээр шүүхэд санал гаргах нь прокурорын эрх хэмжээний асуудал тул дээрх албадлагын шинжтэй таслан сэргийлэх арга хэмжээ (ТСАХ)-ний тоон мэдээг прокурорын байгууллагын бүртгэл мэдээлэл хариуцсан албанаас ирүүлснийг нэгтгэн үзвэл дараах дүр зураг ажиглагдаж байна.

*Хүснэгт 4. Таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдал*

Албадлага, ТСАХ	2017 он	2018 он	2019 он	2020 оны эхний хагас жил
Баривчилсан	299	1,097	1,169	-
Таслан сэргийлэх арга хэмжээ авсан нийт хүн	9,238	18,745	16,980	9,339
Цагдан хорьсон	742	1,677	1,784	1,119
<b>Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлсэн</b>	2	1	-	8

Шинэ эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш таслан сэргийлэх арга хэмжээ авсан тоон үзүүлэлт ихээхэн зөрүүтэй байгаа бөгөөд цахим бүртгэлийн системийг шинэчилж, дата буюу мэдээллийг нөхөн оруулснаас шалтгаалж зарим тоон мэдээ зөрүүтэй гарчээ. Цагдаагийн байгууллага мөрдөгч бие даан авах таслан сэргийлэх арга хэмжээнээс бусад арга хэмжээ, ЭХХШТХ-д заасан үндэслэлээр баривчилсан тоон үзүүлэлтийг гаргадаггүй тул прокурорын байгууллагад хандаж албан ёсны тоон мэдээг<sup>13</sup> авч дүгнэв.

<sup>13</sup> УЕПГ-ын Бүртгэл мэдээлэл, технологийн албанаас албан бичгээр авсан тоон мэдээлэл, 2020.

## Хүснэгт 5. Таслан сэргийлэх зарим арга хэмжээний тоон үзүүлэлт

Хувийн баталгаа гаргах ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.2 дугаар зүйл)				Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.3 дугаар зүйл)				Хязгаарлалт тогтоох ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.5 дугаар зүйл)			
2017	2018	2019	2020 оны эхний 6 сар	2017	2018	2019	2020 оны эхний 6 сар	2017	2018	2019	2020 оны эхний 6 сар
3,029	13,715	13,431	7,919	2	1		8	68	308	426	285

ЭХХШТХ-д 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан шалтгааныг судлан үзвэл “Мөрдөн байцаалтын шатанд бүхий л төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авсан ба тухайн хэрэг нь нотлогдоогүй тохиолдолд хохирол төлүүлэх эрх үүсэхээр байгаа нь учир дутагдалтай, хэрэг нь хэрэгсэхгүй болсон хүн бүхэн нөхөн төлбөр нэхэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой тул хууль бус шинжийг тодотгох, хүний эрхийг ноцтой хязгаарласан, шүүхээс зөвшөөрөл шаарддаг таслан сэргийлэх арга хэмжээний хүрээнд авч үзэх нь зүйтэй”<sup>14</sup> гэж үзжээ.

Судалгааны ажлын хамрах хүрээ энэ шалтгааны улмаас өргөжсөн бөгөөд 2020 оны 2 дугаар сар хүртэл бүхий л төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар авсан гэж үзсэн шалтгааны улмаас нэхэмжлэх эрх үүсэж, зарим тохиолдолд иргэний журмаар нэхэмжилж байжээ. Тухайлбал, “Хязгаарлалт тогтоох” арга хэмжээг жилд дунджаар 360 хүнд авдаг ба “хилээр нэвтрэх хориг”-ийг энэ арга хэмжээний 80 орчим хувьд авдаг байна.

<sup>14</sup> ХЗДХЯ, Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, 2019 оны 10 дугаар сар.



Прокурор Б: “Яллагдагч Б өөрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болсны дараа гадагшаа улс орон руу зорчиход хязгаарлалт тогтоох буюу “хилээр нэвтрэх хориг” тавьсан арга хэмжээг хүчингүй болгоогүйн улмаас хохирол хүлээж, хилийн боомт дээрээс буцаж, үүнээс учирсан хохирлоо ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасны дагуу нэхэмжилж байсан”. Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Б-д таслан сэргийлэх арга хэмжээ авснаас үүссэн гэм хорыг хангаж шийдвэрлэсэн. Саяхан 2020 онд ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт орсон нэмэлт, өөрчлөлтөөр энэ боломжийг хязгаарласан.”

Дээрх шалтгааны улмаас барьцаа авах, хувийн баталгаа гаргах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээний тоог он тус бүрээр гарган дүгнэхэд давхардсан тоогоор жилд дунджаар 18,800 орчим хүнд таслан сэргийлэх арга хэмжээг шат дараалан болон үргэлжүүлэн авчээ.

*Хүснэгт 6. Таслан сэргийлэх зарим арга хэмжээний талаарх тоон үзүүлэлт*

Барьцаа авах ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.6 дугаар зүйл)				Цагдан хорих ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.9 дүгээр зүйл)				Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах ТСАХ (ЭХХШТХ-ийн 14.14 дүгээр зүйл)			
2017	2018	2019	2020 оны эхний 6 сар	2017	2018	2019	2020 оны эхний 6 сар	2017	2018	2019	2020 оны эхний 6 сар
2	17	7	3	215	1,677	1,784	1,119	1	4	12	5

Судалгааны хүрээнд дээрх таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар авсан тохиолдол бий эсэхийг судлахад тоон үзүүлэлтээр гаргах боломжгүй байсан бөгөөд гагцхүү тухайн байгууллагын дотоод хяналт шалгалт, мэргэжлийн үйл ажиллагааг хянах чиг үүрэг бүхий нэгжээс гаргуулан авах боломжтой байв. Гэвч цагдаа, прокурорын байгууллага дээрх үзүүлэлттэй холбоотой тоо баримт

“байгууллагын нууц, албаны нууцлалд хамаардаг” гэсэн шалтгаанаар гаргаж өгөхөөс татгалзсан болно.

Дээр дурдсан тоон мэдээлэл нь зөвхөн нэг жилд бүртгэгдэж, шалгагдсан мөрдөн байцаалтын хэргийн тухайд гаргасан үзүүлэлт бөгөөд энэхүү үзүүлэлт шүүхийн статистикт тухайн онд шийдвэрлэгдсэн бүхий л эрүүгийн хэргийн хүрээнд гардгаараа ялгаатай. Өөрөөр хэлбэл, тухайн шүүхээр шийдвэрлэгдсэн таслан сэргийлэх арга хэмжээний тоон мэдээнд 1-10 хүртэлх жилийн өмнө үйлдэгдсэн эрүүгийн хэрэг ч хамрагдах боломжтой. Энэ нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны дотор мөрдөн байцаалтад шалгагдаж буй бүхий л эрүүгийн хэргийн хүрээнд гаргадаг учраас статистик илт зөрүүтэй гарсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

#### ◆ **Сэжигтнийг баривчлах арга хэмжээ (шүүхийн зөвшөөрлөөр)**

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш 2019 он дуусталх хугацаанд нийт 397 хүнийг сэжигтнээр баривчлуулах саналыг прокуророос шүүхэд ирүүлжээ. Үүний 310 буюу 78.1 хувийг баривчлах зөвшөөрөл олгожээ. Сэжигтнээр баривчлах зөвшөөрөл олгоогүй хүмүүсийг сулласан үндэслэлийг нарийвчлан авч үзвэл 47 буюу 54.0 хувьд нь гэмт хэрэг үйлдсэн хангалттай баримт байхгүй, 13 буюу 14.9 хувь нь ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйлийг зөрчсөн, 13 буюу 14.9 хувь нь баривчилснаас хойш 48 цаг дуусаж, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй гэсэн үндэслэлээр тус тус суллаж шийдвэрлэсэн байна.

*Хүснэгт 7. Сэжигтнийг баривчлах арга хэмжээний тоон мэдээ (шүүхийн зөвшөөрлөөр)*

Огноо	Баривчлуулахаар ирүүлсэн хүн	Баривчлагдсан хүн	Зөвшөөрөл олгоогүй	Сэжигтнийг сулласан үндэслэл		
				Гэмт хэрэг үйлдсэн хангалттай баримт байхгүй	ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйлийг зөрчсөн	Баривчилснаас хойш 48 цаг дуусаж, шийдвэр ирээгүй
2017 он	49	36	13	10	3	0
2018 он	116	87	29	18	0	11
2019 он	232	187	45	19	10	16
<b>Нийт</b>	<b>397</b>	<b>310</b>	<b>87</b>	<b>47</b>	<b>13</b>	<b>27</b>

Эрүүгийн хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2018, 2019 оныг харьцуулж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо өмнөх оноос 116 хүнээр буюу хоёр дахин, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 100 хүнээр буюу 2.1 дахин, баривчлах зөвшөөрөл олгоогүй хүний тоо 16 хүнээр буюу 55.2 хувиар тус тус өсжээ.

◆ **Таслан сэргийлэх арга хэмжээ (шүүхийн зөвшөөрлөөр)**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 он дуусталх хугацаанд нийт 11,153 хүн, хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар прокурор санал гаргажээ. Үүнээс 9,801 хүнд цагдан хорих, 1,275 хүнд хязгаарлалт тогтоох, 77 хүнд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус шүүхээс авчээ.

## Хүснэгт 8. ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн)

Огноо	Прокуророос ТСАХ авахаар ирүүлсэн	Цагдан хорих ТСАХ авахаар ирүүлсэн хүн	Хязгаарлалт тогтоох ТСАХ авахаар ирүүлсэн хүн	ТҮААҮ-ийг түдгэлзүүлэхээр ирүүлсэн
2017 он	1,399	1,199	196	4
2018 он	5,071	4,647	399	25
2019 он	4,683	3,955	680	48
Нийт	<b>11,153</b>	<b>9,801</b>	<b>1,275</b>	<b>77</b>

Таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн прокурорын саналын 87.9 хувийг цагдан хорих, 11.4 хувийг хязгаарлалт тогтоох, 0.7 хувийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ тус тус эзэлж байна. Шүүхээс 2018 онд 3,747 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож байсан бол 2019 онд 3,162 болж 585 хүн буюу 15.6 хувиар буурчээ.

## Хүснэгт 9. Цагдан хорих ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн)

Огноо	Шүүхээс цагдан хорихоор зөвшөөрсөн хүн	Тайлбар: Прокурорын байгууллагын тухайн жилд авсан цагдан хорих ТСАХ-ний тоо 2018 онд 1,677, мөн 2019 онд 1,784 байснаас шүүхийн дээрх тоон мэдээ даруй хоёр дахин өндөр үзүүлэлттэй байгаа нь тухайн жилд шийдвэрлэгдсэн өмнөх онуудын бүх хэргийг хамарсан гэдгийг анхаарна уу.
2017 он	691	
2018 он	3,747	
2019 он	3,162	
Нийт	<b>7,600</b>	

Цагдан хорих зөвшөөрлийн:

- 12.9 хувийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”;
- 12.9 хувийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”;
- 0.1 хувийг “Мөрдөгчийг дарамталсан, сүрдүүлсэн”;
- 1.4 хувийг “Хохирогчийг дарамталсан, сүрдүүлсэн”;
- 0.6 хувийг “Гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”;
- 0.3 хувийг “Гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн”;
- 1.3 хувийг “Өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа”;
- 0.9 хувийг “Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”;
- 0.3 хувийг “Гэрчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”;
- 0.3 хувийг “Гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”;
- 31.6 хувийг “Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”;
- 16.2 хувийг “Урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”;
- 0.5 хувийг “Шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”;
- 4.9 хувийг “Прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”;
- 15.7 хувийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” гэсэн үндэслэлээр тус тус зөвшөөрөл олгожээ.

**Шүүгч О:** Хууль бусаар таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь тогтоогдсон тохиолдол бараг байхгүй. Учир нь шүүхийн зөвшөөрлөөр авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээг прокуророос санал гаргах үед хууль зүйн үндэслэл бий болсон эсэхийг тухайн хэрэгт авагдсан баримт сэлтийг шүүгч үнэлж шийдвэрлэдэг. Харин хууль зүйн үндэслэл, бодит баримт сэлт байхгүй тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авахаас татгалзаж шийдвэрлэдэг. ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан “хууль бусаар” гэснийг хэрхэн тогтоох нь одоог болтол ойлгомжгүй байна. Шүүхээс зөвшөөрөл олгож хэрэгжүүлсэн таслан сэргийлэх арга хэмжээ нь бүхэлдээ хууль ёсны дагуу хийгддэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш 667 хүнийг шүүхийн шатанд цагдан хорьж, 3,682 яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг давхардсан тоогоор 7,558 удаа сунгаж, 834 яллагдагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, 541 яллагдагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, 827 хүнийг цагдан хорихоос татгалзан шийдвэрлэжээ.

Шинэ эрүүгийн хууль тогтоомж үйлчилж эхэлснээс хойш сэжигтнийг баривчлах болон цагдан хорих, эрх хязгаарлах, албан үүргийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамж 2017 онд 2,172; 2018 онд 7,036; 2019 онд 8,543 гарсан буюу өссөн дүнтэй байна.

2019 онд яллагдагчаар цагдан хорих тухай 1,878, цагдан хорих хугацааг сунгах тухай 3,598, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 342, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай 598, шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай 722 захирамж гарсан нь нийт 8,543 захирамжийн 83.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. ТСАХ-ний тоон мэдээ (шүүхийн зөвшөөрлөөр)

№	Шүүгчийн захирамж	Огноо				
		2017 оны 7 сараас хойш	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан шүүгчийн захирамж	2,172	7,036	8,543	1,507	21.4
2	Сэжигтнийг баривчлах тухай	34	78	188	110	141
3	Сэжигтнийг баривчлахаас татгалзах тухай	11	6	12	6	100
4	Сэжигтнийг суллах тухай	5	21	34	13	61.9
5	Яллагдагчаар цагдан хорих тухай	477	1,572	1,878	306	19.5
6	Яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	113	266	158	-108	-40.6
7	Шилжүүлэн цагдан хорих тухай	8	91	105	14	15.4
8	Шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	1	0	5	5	-
9	Цагдан хорих хугацааг сунгах тухай	646	3,206	3,598	392	12.2
10	Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	90	186	220	34	18.3
11	Шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай	102	203	722	519	3.6 дахин
12	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	122	215	181	-34	-15.8
13	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	194	354	342	-12	-3.4
14	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	136	360	246	-114	-31.7

## Хүснэгт 10-ын үргэлжлэл

15	Тогтоосон газраас гарч явах тухай	5	3	10	7	3.3 дахин
16	Тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явах тухай	5	7	33	26	4.7 дахин
17	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай	187	377	598	221	58.6
18	Тодорхой газар очихыг хязгаарлах тухай	0	3	8	5	2.7 дахин
19	Тодорхой хүнтэй уулзахыг хориглох тухай	2	20	63	43	3.2 дахин
20	Тогтоосон замаар зорчихыг даалгах тухай	0	0	2	2	-
21	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	9	3	53	50	17.7
22	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	20	42	67	25	1.6
23	Төрийн албанд ажиллахыг түдгэлзүүлэх тухай	2	0	12	12	-
24	Тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлэх тухай	1	8	2	-6	-75
25	Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	0	13	0	-13	-
26	Тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	1	2	2	0	0
27	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэхийг сэргээх тухай	1	0	4	4	-



**Сэжигтнийг баривчлах арга хэмжээ:** Монгол Улсын хэмжээнд 2020 оны эхний хагас жилд шүүх 111 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 100 сэжигтнийг буюу 90.1 хувьд нь баривчлах зөвшөөрөл олгож, 11 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Баривчлах зөвшөөрөл олгосон нийт 100 хүний 30 хувийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр, 70 хувийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр олгосон байна.

**Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ:** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1, 14.9 дүгээр зүйлд зааснаар 2020 оны эхний хагас жилд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахтай холбоотой давхардсан тоогоор 2,812 материал хүлээн авснаас шүүхээс 1,085 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож, 223 хүнийг цагдан хорихоос татгалзаж, 1,543 хүний цагдан хорих хугацааг сунгаж, 154 хүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, 64 хүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн байна. 157 хүнд шүүхийн шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ.

ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан нэхэмжлэл гаргах гол үндэслэл болсон “хууль бус”-аар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан эсэхийг хэрхэн тогтоохыг хуульчдаас тодруулахад прокуроруудын 60 хувь нь хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй биечлэн уулзах, гүйцэтгэх ажиллагаа явуулах, нотлох баримтад түшиглэн мөрдөн шалгах ажиллагаа явуулна гэжээ. Харин мөрдөгчдийн 42 хувь нь ийм тохиолдол таараагүй, мэдэхгүй, тогтооход хүндрэлтэй гэсэн бол шүүгчдийн 51 хувь нь хууль бусаар баривчилсан, цагдан хорьсныг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрээр, өмгөөлөгчдийн дийлэнх нь хохирсон хүмүүсийн гомдлыг үндэслэн шалгаж тогтооно гэж хариулсан байна. Мөн хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах болон албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээг “хууль бусаар” авсан тохиолдлыг хэрхэн тогтоох арга замыг дээрхтэй ижил хариулжээ.

ЭХХШтХ-ийн 45.2 дугаар зүйлийн 2.1-д (өмнө нь 2.2 дахь хэсэг байсан) 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд энэ журмаар нэхэмжлэл гаргах эрх 5/1 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл, жилд 18,000 орчим хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авагддагаас 2,000 орчим тохиолдолд энэ журмаар нэхэмжлэх эрх үүсэх боломжтой байсан бол нэхэмжлэх эрх үүсэх үндэслэлийг цөөн төрлийн ТСАХ болгож өөрчилснөөр энэ тоо 400 орчим болж, тав дахин буурчээ.

### 2.2.3. Цагаатгасан шүүхийн шийдвэрийн тоон мэдээ<sup>15</sup>

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад гэмт хэргийн шинжгүй нь тогтоогдвол шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана” гэж заасан. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 43,774 хэргийг хүлээн авснаас 37,689 хэрэг буюу 86.1 хувийг хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн хэргээс 151 хэрэг буюу 0.4 хувийг цагаатгаж шийдвэрлэжээ.

#### Хүснэгт 11. Цагаатгасан хэргийн тоон мэдээ

№	Нутаг дэвсгэр	Анхан шатны шүүхийн шийдвэр										
		Нийт хүлээж авсан хэргийн тоо				Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо				Цагаатгасан хэргийн тоо		
		2017	2018	2019	2020 он хагас	2017	2018	2019	2020 он хагас	2017	2018	2019
1	Нийслэл	2,465	7,605	8,405	5,192	1,881	6,579	7,362	4,152	15	21	32
2	Орон нутаг	2,594	5,450	5,768	3,453	2,259	4,972	5,164	2,817	23	31	19
3	Сум дунд (төрлөөр дагнаагүй шүүх)	429	899	993	521	385	812	871	435	2	3	5

<sup>15</sup> Шүүх хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл (2017-2019).

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх судалгаанд хамрагдсан хугацаанд нийт 151 хэргийг цагаатгаж шийдвэрлэсэн ч тухайн цагаатгасан хэргийн хэдэд прокурор эсэргүүцэл бичиж, давж заалдах шатны шүүх хэрхэн шийдсэн тухай тоон мэдээг гаргах боломжгүй байв.

Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхим 2017-2019 онд нийт 2069 хэрэг хүлээн авснаас 1,976 хэрэг буюу 95.5 хувийг хянан шийдвэрлэжээ. Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхим сүүлийн 3 жилийн хугацаанд 15 хэргийг цагаатгаж шийдвэрлэжээ.


*Хүснэгт 12. УДШ-ээс цагаатгасан хэргийн тоон мэдээ*

Огноо	2017	2018	2019
Цагаатгал	5	1	9

**2.2.4. Гэмт хэргийн шинжгүй эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон тоон мэдээ**


Шинэ эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 58,806 гэмт хэрэгт 68,289 хүнийг яллагдагчаар татсан байна.

График 1. Мөрдөн байцаалтын хэрэг, яллагдагчаар татсан хүний тоо



Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хүний тоо нэг жилд дунджаар 18,000 байгаа бөгөөд 12,000 яллагдагчид холбогдох хэрэг шүүхэд шилжиж, үлдэгдэл 6,000 орчим эрүүгийн хэрэг мөрдөн байцаалтад шалгагддаг ажээ. Дээр дурдсан хугацаанд буюу 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш 780 яллагдагчид хамаарах 734 гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлийн 32.5.1.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

График 2. Хэрэгсэхгүй болгосон хэрэг, яллагдагчийн тоо




Цагдаагийн байгууллагын дээрх тоон мэдээг прокурорын байгууллагын цахим бүртгэлийн системээс гаргасан тоон мэдээтэй тулгаж үзэхэд 97 хэргээр зөрүүтэй (их) байсан бөгөөд энэ нь мөрдөгчийн санал, прокуророос гарсан эцсийн шийдвэрээс хамааран зөрсөн байх магадлалтай.

*Хүснэгт 13. Хэрэгсэхгүй болгосон хэрэг (прокурорын байгууллагын мэдээ)*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлийн 32.5.1.1 дэх хэсэг (Гэмт хэргийн шинжгүй)-т заасан үндэслэлээр			
2017 он	2018 он	2019 он	2020 оны эхний хагас
<b>190</b>	<b>183</b>	<b>191</b>	<b>73</b>

Өөрөөр хэлбэл, дурдсан хугацаанд цагдаагийн байгууллага 734 хэргийг гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгохоор санал гаргаж прокурорт шилжүүлсэн бол прокуророос 637 хэргийг дээрх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Энэ мэтчилэн он оноор тулгаж үзэхэд нэг жилд 25-30 хэргээр зөрүүтэй гарч байна. Судалгааны хамрах хугацаанд буюу 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 он хүртэл эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нийт 30,503 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд жилд дунджаар 1.2 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*График 3. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэрэг*



Сүүлийн гурван жилийн хугацаанд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хүлээн авч хянан шийдвэрлэсэн, үүнээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа.

*Хүснэгт 14. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэрэг*

Он		2017	2018	2019
<b>ЭРҮҮГИЙН ХЭРЭГ</b>	Нийт хэрэг	8,839	12,551	13,427
	Хэрэгсэхгүй болсон хэрэг	865	150	218
	Эзлэх хувь	9.8	1.2	1.6
	Нийт хянан шийдвэрлэсэн хүний тоо	10,040	15,037	15,366
	Яллагдагчид холбогдох үйлдлийг хэрэгсэхгүй болгосон тоо	1,222	319	344
	Хувь	12.2	2.1	2.3

Шүүхийн тоон мэдээнээс үзвэл<sup>16</sup> 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 290 хүнд холбогдох 221 хэргийг, давж заалдах шатны шүүхүүд 86 хүнд холбогдох 64 хэргийг, хяналтын шатны шүүх 67 хүнд холбогдох 60 хэргийг Эрүүгийн хууль (ЭХ)-ийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэсэн үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд судалгаанд хамрах хугацаанд нийт 368 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Үүний 224 буюу 60.9 хувь нь гэмт хэргийн шинжгүй, 80 буюу 21.7 хувь нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан,

<sup>16</sup> 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оны эхний гурван улирлын байдлаар шүүх хүлээн авч хянан шийдвэрлэсэн хэрэгт “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн талаарх судалгаа.

17 буюу 4.6 хувь нь шүүгдэгч нас барсан, 15 буюу 4 хувь нь тухайн хэргийг өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа, 11 буюу 2.9 хувь нь тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, 2 буюу 0.5 хувь нь шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ял оногдуулах насанд хүрээгүй, 6 буюу 1.6 хувь нь шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй болох нь тогтоогдсон, 13 буюу 3.5 хувь нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон гэсэн үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*Хүснэгт 15. Шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдсэн хэргийн үндэслэл*

№	Үзүүлэлт	2017 оны 7 сараас хойш	2018 он	2019 он	2020 он хагас жил	Нийт
1	Гэмт хэргийн шинжгүй	40	83	84	17	<b>224</b>
2	Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан	20	42	14	4	<b>80</b>
3	Шүүгдэгч нас барсан	11	3	3	0	<b>17</b>
4	Тухайн хэргийг өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа	8	4	0	3	<b>15</b>
5	Тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон	6	0	5	0	<b>11</b>
6	Шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ял оногдуулах насанд хүрээгүй	0	1	0	1	<b>2</b>
7	Шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй болох нь тогтоогдсон	2	1	2	1	<b>6</b>
8	Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон	3	6	4	0	<b>13</b>

Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад гэмт хэргийн шинжгүй нь тогтоогдвол шүүн таслах ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргадаг. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй эсхүл гэмт хэргийн шинжгүй гэж үзэж хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт заасан нэхэмжлэл гаргах эрх үүсэх боломжтой.

**Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч О:** Энэ төрлийн журмаар гаргасан нэхэмжлэлд Засгийн газрыг хариуцагчаар тогтоодог ба Засгийн газраас үүрэг болгосны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас холбогдох мэргэжилтнийг томилдог. Миний хариуцагчаар томилогдон орсон нэг тохиолдол нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэрэгт хүнийг хууль бусаар цагдан хорьсонтой холбоотой нэхэмжлэл байсан ба тухайн хэрэгт шүүгдэгчийг гэм буруутай гэж үзсэн боловч аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж үзэж хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байсан. Нэхэмжлэгч гэм буруутай атлаа тухайн хэрэг нь хэрэгсэхгүй болсон тул тухайн хэрэгт яллагдагчаар 75 хоног цагдан хоригдсон гэм хорыг нэхэмжилснийг шүүхээс зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн. Тухайн хуралд төрийг төлөөлж оролцсон прокурор мөрдөн шалгах бүхий л ажиллагаа хууль ёсны байсан тухай тайлбарлахад хүлээн аваагүй нь эргэлзээтэй санагдсан.

ЭХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялаас чөлөөлсөн, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, уучлал үзүүлсэн, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй эсхүл тухайн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон, ял, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн хууль батлагдсанаар хүчингүй болсон, өөрчлөгдсөн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй” гэсэн боловч “гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон” нь хамаарах эсэхийг тусгаагүй байна. Практикт гэм буруутай нь тогтоогдсон боловч дээрх тохиолдлоор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн хүн өөрийгөө гэм буруугүй, хууль бусаар мөрдөн шалгагдсан гэж үзэж ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт заасан үндэслэлээр Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргадаг.



Судалгааны хүрээнд мөрдөгч, прокурор шүүгчдээс авсан санал асуулгаар тухайн үйлдэл гэмт хэргийн шинжгүй байх, тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох нь хууль бус ажиллагаанд тооцогдох эсэхийг судалгаанд оролцсон нийт 40 хуульч бүгд үгүй гэж хариулсан нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, бүх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэдэг ба хэрэв хүний эрхийн зөрчил гаргаж, хууль бус ажиллагаа явуулбал прокурор хяналтаараа алдааг засаж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг хуульд заасан арга хэрэгслээр зөвтгөдөг гэж үзжээ.


Өөрөөр хэлбэл, тухайн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэгдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, шүүхээс дээрх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан тохиолдолд хууль бус ажиллагаанд хамаарахгүй, мөрдөн шалгах бүхий л үйл ажиллагаа хууль ёсны дагуу хийгддэг тул ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан нэхэмжлэл гаргах эрх үүсэхгүй гэж санал асуулгад оролцсон нийт мөрдөгч, прокурор үзсэн. Гэтэл энэ чиглэлээр сүүлд хийгдсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнд<sup>17</sup> “ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан үндэслэлээр шийдвэрлэсэн иргэний хэргийн хяналтын шатны шүүхээс тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэсэн бүхий л тохиолдолд мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаанаас үүссэн гэм хорыг нэхэмжлэх эрх үүсэх ба хууль бус гэдгийг заавал тогтоох шаардлагагүй гэж үзэж зарим хэргийг шийдвэрлэсэн гэжээ”.

### 2.2.5. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тоон мэдээ

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны эхний 5 сарын хугацаанд Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг”-ийн 12 дугаар зүйл “Эрүү шүүлт тулгах” нийт 76 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

<sup>17</sup> Нээлттэй Нийгэм Форум, Н.Норовсамбуу, Ж.Содномдаржаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”-ний тайлангаас

График 4. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тоон мэдээ



Харин прокурорын байгууллагын мэдээллийн сангаас үзвэл бүртгэгдсэн гэмт хэргээс шийдвэрлэгдсэн тохиолдол цөөн байх бөгөөд нийт зургаан хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Хүснэгт 16. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шийдвэрлэлт

	Мөрдөн байцаалт явуулсан	өмнөх оны	тухайн онд ЭХҮЯ татсан	шүүхэд шилжүүлсэн	хэрэгсэхгүй болгосон	нэгтгэсэн	үлдэгдэл
2017 эхний хагас	1	-	1	1	-	-	-
2018 он	4	2	2	1	1	-	2
2019 он	5	2	3	3	-	1	1
2020 оны эхний хагас	2	1	1	1	-	-	1

Шүүхийн тоон мэдээнээс үзвэл энэ гэмт хэрэгт ял шийтгүүлсэн гурван тохиолдол байх бөгөөд тухайн хэргийн хохирогч ЭХХШТХ-ийн 45 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэл гаргасан эсэх нь тодорхойгүй байна. Судалгааны хүрээнд яллагдагч, шүүгдэгчийг эрүүдэн шүүсэн болохыг хэрхэн нотлох талаар санал асуулгаар судлахад прокуроруудын 47 хувь нь тухайн хүн, түүний өмгөөлөгч, ар гэрийнхэнтэй биечлэн уулзах, биед нь үзлэг хийх, шинжээч томилох, камерын бичлэг хийх зэргээр тогтооно гэж үзсэн байхад шүүгчдийн 71 хувь нь прокурорын дүгнэлт, нотлох баримтад үндэслэнэ гэжээ.

Харин мөрдөгчдийн дийлэнх нь хуульд заасны дагуу мөрдөн шалгаж гэсэн бол 10 хувь нь мэдэхгүй гэж, өмгөөлөгчдийн 55 хувь нь гомдол хүсэлт гаргах, үзлэг хийх, шинжээч томилуулах зэргээр нотолно гэж хариулсан байна. Үүнээс үзвэл эрүүдэн шүүсэн тохиолдолд тухайн гэмт хэргийг нотолж, гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны үндсэн дээр ЭХХШТХ-ийн 45 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэл гаргах эрх үүсэж байна.

### 2.3. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан бөгөөд нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын агуулгаар эрүүгийн гэмт хэрэгт шалгах эрх бүхий албан тушаалтан, байгууллагын ажиллагаа хууль ёсоор явагдсан хэдий ч эцэст нь тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны эрх зүйн үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй этгээдээс шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль бус ажиллагааны улмаас хохирсон гэж шүүхэд нэхэмжлэл гаргасан хэргүүдийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх судалгааг хийхдээ Монгол Улсын Шүүхийн цахим санд бүртгэгдсэн Иргэний хэргийн шүүхийн 96 шийдвэрийг уншиж нэгтгэн дүгнэлээ.

Шүүхийн статистик мэдээ болон судалгаагаар ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасан үндэслэлээр иргэний журмаар нэхэмжлэл гаргасан тохиолдол, түүнд хамаарах үзүүлэлтийг нэгтгэн гаргадаггүй ажээ. Прокурорын байгууллагын цахим бүртгэл болон Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой хийсэн судалгааны дүнгээс үзвэл 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2018 он хүртэлх хугацаанд мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас гэм хор нэхэмжилсэн 21, 2018 онд 43, 2019 онд 29 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцжээ.<sup>18</sup>

<sup>18</sup> Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн нэгдсэн системээс тоолж гаргасан тоо.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох байгууллагад албан бичгээр хандаж хүссэн боловч энэ талаар мэдээлэл өгөх боломжгүй, албаны болон хувийн нууцад хамаарах дотоод асуудал тул мэдээлэл гарган өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Иймд судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрийн цахим сангаас хайлт хийх замаар 2015-аас 2017 оны хооронд буюу ЭБШХ үйлчилж байх үед шийдвэрлэсэн 69, 2017 онд 9, 2018 онд 10, 2019 онд шийдсэн 8 шүүхийн шийдвэр тус бүрийг хамруулав.

График 5. Нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал



Судалгааны хүрээнд Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон болон түүнийг хангаж шийдвэрлэсэн хууль зүйн үндэслэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар барагдуулах зургаан төрлийн хохирлыг нотлох баримтад үндэслэн үнэлж, тогтоосон байдал зэргийг судлав.

### 2.3.1. Иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээр Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 15 шийдвэрийн хоёр тохиолдолд тухайн хэрэг нь өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдсан, 13 тохиолдолд ЭБШХ болон ЭХХШтХ-д хууль бусаар

эрх нь зөрчигдсөнтэй холбоотой нэхэмжлэлд заасан эрх үүсээгүй, мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас болсон гэдгийг тогтоогоогүй, тухайн хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан хэмээн үзэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Судалгааны хүрээнд мөрдөгч, прокурор, шүүгчээс “гэмт хэргийн шинжгүй эсвэл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд ямар учраас өөрсдөө гомдол гаргадаггүй болох”-ыг тодруулахад “олон шат дамжлага хуулийн байгууллагын чирэгдлээс залхдаг, хуулийн байгууллагад дахин хандахаас төвөгшөөдөг” гэж 36 хувь, “гомдол гаргах эрхийг тайлбарлаж өгөөгүй учир” гэж 10 хувь, “хэргийг хэрэгсэхгүй болгож хаасанд сэтгэл ханамжтай үлддэг” гэж 53 хувь, “учирсан хохирлыг нэхэмжлэхээс сайн дураараа татгалздаг, өөрт нь ашигтай байдаг” гэж 1 хувь нь тус тус үзжээ.

Дээрх шалтгаанаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруутай нь нотлогдоогүй, тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг хэрэгсэхгүй болгосон хэргийн яллагдагч өөрт учирсан хохирлоо нэхэмжилдэггүй, энэ талаар хуульд заасан үндэслэлийг тайлбарлаж өгдөггүй тул ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт заасны дагуу нэхэмжлэл гаргадаггүй ба энэ талаар мэдээлэлгүй байдаг ажээ.

**Нэхэмжлэл гаргагч А:** 2017 онд би гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэгт буруутгагдан ял шийтгэгдсэн. Улмаар тухайн үйлдэл нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, өөр гэмт хэргийн шинжтэй гэж үзэж давж заалдах шатны шүүхээс торгох шийтгэл оногдуулсан. Энэ хэрэгт мөрдөгч нь хохирогчтой хувийн харилцаа үүсгэж, намайг 14 хоног цагдан хорих шийдвэрийг прокурор, шүүхээр гаргуулж байсан. Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжид энэ тухай гомдол гаргаж мөрдөгч нь хохирогчтой хувийн харилцаа үүсгэсэн нь тогтоогдсон. Дээрх үйл баримтын үндсэн дээр би ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт заасны дагуу нэхэмжлэл гаргасан боловч хүлээн аваагүй. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан хууль зүйн үндэслэл нь “нэхэмжлэл гаргах эрх үүсээгүй” гэсэн.

Иргэний журмаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдээс

үзэхэд тухайн хэрэг нь эцэслэн шийдвэрлэгдээгүй, нотлох баримт гаргаж өгөөгүй, өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдсан гурван тохиолдлоос бусад 12 хэрэгт гэм буруутай нь нотлогдоогүй, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй хүний нэхэмжлэлийг мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас болсон гэдгийг тогтоогоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. ЭХХШТХ үйлчилж эхэлснээс хойш тухайн иргэний хэрэгт төрийг төлөөлж оролцож байгаа Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурор, хэргийг шийдвэрлэсэн шүүгч нь “хууль бус ажиллагааны улмаас” гэдгийг заавал тогтоох талаар зөрүүтэй байр суурьтай байсантай холбоотой гэж үзэж болохоор байна.

**Прокурор Х.Б:** 2018 онд Г.У-ийн нэхэмжлэлтэй хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн тогтоол нь шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль бус ажиллагааны улмаас учирсан гэм хорыг арилгуулах хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхээс тогтоосон жишиг болсон. Иргэний хэргийн анхан шатны шүүхээс өмнө нь шийдвэрлэж байсан хууль зүйн үндэслэл, дүгнэлтүүд харилцан адилгүй байсан бөгөөд дээрх тогтоол гарснаар нэг мөр шийдвэрлэгдсэн гэж үзэж болно. Ингэснээр өмнө нь прокурор, шүүгчид хоорондоо маргадаг байсан “хууль бус” гэдгийг заавал тогтоох шаардлагагүй болсон.

Улсын Дээд Шүүхээр шийдвэрлэсэн энэ төрлийн иргэний нэхэмжлэлтэй холбоотой жишиг шийдвэрт<sup>19</sup> “хууль бус гэдгийг” тайлбарлахдаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан бөгөөд нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын агуулгаар эрүүгийн гэмт хэрэгт шалгах эрх бүхий байгууллагын хууль ёсны ажиллагаа явагдсан хэдий ч эцэст нь тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны эрх зүйн үр дагаврыг

<sup>19</sup> Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 411 дүгээр тогтоол.

төр хариуцах үүрэгтэй болдог. Эрүүгийн байцаан шийтгэх тухай 2002 оны хуулийн 388 дугаар зүйлийн 388.1-д, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн үр дагаврын талаар заасан боловч энэхүү ажиллагаанд холбогдох албан тушаалтны хууль бус үйлдэл бүхий ажиллагаа хамаарахаас гадна яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа ч мөн адил хамаарна. Учир нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрх зүйн презумпци нь иргэн бүрийг эрхийн үндэслэлгүй хязгаарлалтаас хамгаалах зарчим юм. Ийнхүү төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд дээрх эрхийн хязгаарлалт хууль бусд тооцогддог болно. Улмаар үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд “хууль бус ажиллагаа”-нд хамааруулдаг. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй байна” гэж дүгнэсэн.

Хэдийгээр ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн гарчиг болон 45.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэх эрх үүсэх үндэслэлд “хууль бус ажиллагааны улмаас” гэж хууль тогтоогчоос заасан хэдий ч 2019 оноос хойш шийдвэрлэгдэж байгаа энэ төрлийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт дээрх хууль зүйн дүгнэлтийг жишиг болгон хэрэглэж байгаа нь Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцсэн практик юм.

### 2.3.2. Мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг тогтоож, үнэлж, нөхөн төлүүлсэн байдал

Судалгааны хүрээнд ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийн зургаан төрлийн хохирол, ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйлд заасан сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлж тогтоон, нөхөн төлүүлсэн байдалд дүн шинжилгээ хийв. Энэ төрлийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн 81 шийдвэрийн хувьд хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг гаргуулсан 79 хэрэг, хууль бусаар цагдан хоригдсон, хэрэгт шалгагдсаны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлогыг гаргуулсан 59 хэрэг байна. Мөн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн 81 шийдвэрийн хувьд доод тал нь 300,000 төгрөгөөс дээд тал нь 87,263,200 төгрөгийн хоорондох хохирлын мөнгөн дүнг төрөөс гаргуулахаар шийдвэрлэжээ.

#### **Тохиолдол 1.**

Д-г онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан 2009 онд эрүүгийн хэрэг үүсгэж, зургаан жилийн турш шалгасан. Энэ хугацаанд Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг хориглож, эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, сэжигтнээр гурав хоног баривчилсан. Энэ хэргийг прокуророос хоёр удаа, дүүргийн шүүхээс нэг удаа хэрэгсэхгүй болгосон боловч 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэгт зааснаар 10 жил 1 сарын хорих ял, мөн 100,000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ялаар шийтгэсэн. Улсын Дээд Шүүхээс 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож, Д-г цагаатгасан. Энэ хэрэгт:

- ♦ Эд хөрөнгийн хохиролд 118,365,140 төгрөг, үүнд:
  - Олон улсын карго эрхэлж, дөрвөн жилд олох ёстой байсан орлого 50 сая төгрөг;
  - Гадаад худалдаа эрхэлж болохгүй болсны улмаас алдсан ашиг, орлого 7,500,000 төгрөг;



- “Барилгын материал худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж 240.0 сая төгрөгийн цахилгаан утас нэг жилийн хугацаанд нийлүүлэх гэрээ байгуулж ажиллаж байсан. Дээрх хугацаанд хоригдсоноос гэрээ тасалдсан тул олох ёстой байсан орлого 47,320,000 төгрөг;
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хийгдсэн эдийн засгийн шинжээч, аудитын дүгнэлтэд төлсөн 810,000, хууль зүйн туслалцаа авсан 7,700,000, нотариат болон үйлчилгээний зардалд төлсөн 52,600 төгрөг тус тус, мөн хохиролд төлүүлсэн 4,000 ам.доллар буюу 4,982,440 төгрөг.
- ◆ Сэтгэл санааны хохиролд 50.0 сая төгрөг нийтдээ 168,365,140 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэж нэхэмжилжээ.

Шүүхээс нэхэмжлэгч Д-д эд хөрөнгийн хохирлын шаардлагад 45,263,200, эдийн бус сэтгэл санааны хохиролд 42,000,000 төгрөг тус тус, нийт 87,263,200 төгрөгийн хохирлыг барагдуулахаар шийдвэрлэсэн.

### ***Тохиолдол 2.***

К-г Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэж 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. К нь хууль зүйн туслалцаа авахад өмгөөлөгчид төлсөн хөлс 300,000 төгрөг, сэтгэл санааны хохирол болох 200,000 төгрөг, нийт 500,000 төгрөгийн хохирлыг нэхэмжилсэн. Шүүхээс өмгөөлөгчийн дансанд 150,000 төгрөг төлсөн баримт ... аймаг дахь Цагдаагийн газарт очиж, К-д холбогдох ... тоот эрүүгийн хэрэгт үзлэг хийсэн тэмдэглэл зэрэг нотлох баримтыг үндэслэж 300,000 төгрөгийн хохирлыг барагдуулахаар шийдвэрлэсэн.

Мөн хуулийн этгээдийн орлогыг хоёр хэрэгт гаргаж шийдвэрлэсэн бол хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр, тэтгэмж, шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын гаргуулсан эд хөрөнгө, орлого, эд зүйл, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж гаргуулсан мөнгөн төлбөр, хүн, хуулийн


этгээдээр төлүүлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардал гаргуулсан тохиолдол гараагүй байна.

Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зургаан төрлийн эд хөрөнгийн хохирлоос дээр дурдсан гурван төрлийн хохирлыг гаргуулахаар шийдвэрлэжээ. Харин ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйлд заасан сэтгэл санааны хохирлын үр дагаврыг нэхэмжлэгчийн анх үнэлснээс нь илтэд бууруулж эсхүл бүхэлд нь хэрэгсэхгүй болгож дийлэнх хэрэгт шийдвэрлэжээ.

*А) Хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлогыг шийдвэрлэсэн байдал (ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалт)*

Шүүхийн шийдвэрт дурдсан хууль хэрэглээ, нэхэмжлэгчийн гаргасан хохирлыг тогтоож, үнэлж, нөхөн төлүүлсэн байдлыг үзвэл ажилгүй байсан хугацааны болон олох ёстой байсан цалин орлогын хэмжээг тогтоохдоо цагдан хоригдсон хоногийн нөхөн төлбөр мэтээр ойлгох эсхүл цагдан хоригдсон хугацаанд учирсан сэтгэл санааны хохирлоос ялган салгаж чадахгүй байна.

*График 6. ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан хохирол барагдуулалт*



Мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлсийг тогтооходоо Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тухайн үед тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан<sup>20</sup> эсхүл тухайн иргэний хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд шийдвэрлэж байна.

### **Тохиолдол 3.**

Нэхэмжлэгч А нь эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж 2014 оны 3 дугаар сарын 14-нөөс 2014 оны 8 дугаар сарын 7-ныг хүртэл ажлын 103 хоног ажил эрхлэх боломжгүй болсон байна. Тэрээр нэг хоногийн цалин хөлс 52,727 төгрөг буюу (сард 1,160,000 төгрөг) мөрдөн шалгагдсан 103 хоногт нийт 5,430,881 төгрөгөөр хохирсон гэж нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхээс 5,395,342 төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас олгож шийдвэрлэжээ. А нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар шалгагдаж байхдаа цагдан хоригдоогүй.

Энэ төрлийн нэхэмжлэлтэй холбоотой зарим хэрэгт ажил эрхэлж, орлого олж байснаа нотолж чадаагүй ч ажиллаж байсан үйл баримтыг үндэслэж нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн тохиолдол байна.

<sup>20</sup> Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалингийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаарыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо тогтоодог.

**Тохиолдол 4.**

Нэхэмжлэгч Г.У шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “тухайн үед би “Доктор” авто засварын газарт механикч хийдэг, сарын 850,000 төгрөгийн цалин авдаг байсан. ...Би одоо ажиллаж байх үеийн сарын цалингаа нэхэмжилмээр байгаа ч энэ талаар байгууллагаас баримт гаргуулах боломжгүй байгаа тул ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 20,544,000 төгрөгийг төрөөс гаргуулахаар нэхэмжилнэ” гэжээ. Шүүх нэхэмжлэлийн шаардлагад зааснаар хөдөлмөрийн хөлсний сард тооцогдох доод хэмжээг нэхэмжлэгчийн цагдан хоригдсон 107 хоногт үржүүлэн 20,544,000 төгрөгийн гаргуулахаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, энэ хэрэгт цагдан хоригдсон нэг өдрийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож тогтоожээ.

Мөн дээрх хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан зохицуулалтыг баримтлах шаардлагагүй гэсэн ба Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д заасныг үндэслэсэн нь тус тус хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн зөрчил болжээ. Өөрөөр хэлбэл, шүүхээс Иргэний хуульд заасан хүний нэр төр, алдар хүндтэй холбоотой гэм хорын зохицуулалтыг төсөөтэй хэрэглээгүй гэж дүгнэсэн хэд хэдэн тохиолдол гарсан.

“Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан “бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэх зохицуулалтыг хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасан “хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс

үл хамааран төр хариуцан арилгана” гэх зохицуулалттай давхар баримтлах боломжгүй” гэсэн практик тогтоожээ.<sup>21</sup>

Түүнчлэн энэ төрлийн хохиролтой холбоотой шүүхийн шийдвэрийг судлахад цагдан хоригдсон хоногтой холбоотой нөхөн төлбөрийг хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлстэй адилтган ойлгож, хохирлыг тогтоож шийдвэрлэсэн хэд хэдэн тохиолдол байна.

#### **Тохиолдол 5.**

Нэхэмжлэгч Ц нь Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д зааснаар 2013 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар шийтгэх тогтоолоор гурван жил дөрвөн сарын хорих ялаар шийтгүүлсэн. Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 192 дугаар тогтоолоор Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна. Хэрэгт холбогдож байх хугацаанд ажлаасаа чөлөөлөгдсөн бөгөөд үндэслэлгүйгээр цагдан хоригдсон хугацааны нөхөн төлбөр нэхэмжилжээ. Шүүхээс Ц-ийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн хугацааны мөнгөн дүнг тооцохдоо түүний нэг өдрийн хөлсийг нийт цагдан хоригдсон хугацаанд үржүүлсэн байна. Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлсийг  $577,851 : 21.5$  хоног = 26,876 төгрөг гэж тооцон, хууль бусаар цагдан хоригдсон 245 хоногт үржүүлж, нийт 6,584,620 төгрөгийг олгох үндэслэлтэй гэж шийдвэрлэжээ.

Тохиолдол 3-т гэмт хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдсан хугацаанд авах ёстой байсан цалин хөлсөө тооцож олгосон атал тохиолдол 5-д хорих ялаар шийтгүүлж, нийт 245 хоног цагдан хоригдсон хугацааны олох ёстой байсан цалин хөлсийг ажлын өдөрт хувь тэнцүүлэн бодож, харин яллагдагчаар татагдсан хугацааны олох ёстой байсан орлого, цалин хөлсийг үнэлж, тооцоогүй байна.

<sup>21</sup> Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 411 дүгээр тогтоол.

Энэхүү цагдан хоригдсон хоногийн нөхөн төлбөрт хамаарах шийдвэрийн эрх зүйн үндэслэл нь өмнө үйлчилж байсан буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т “цагдан хоригдсон этгээдэд торгох буюу тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан бол цагдан хоригдсон хугацааг харгалзан шүүх уг ялыг хөнгөрүүлэх буюу ял эдэлсэнд тооцож болно. Цагдан хоригдсон этгээдэд торгох ял оногдуулсан бол цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлж, торгох ялаас хасаж тооцно” гэж заасныг үндэслэн шийдвэрлэж байна. Торгох ялаар шийтгүүлсэн этгээдийн төлбөл зохих төлбөрөөс цагдан хоригдсон хоногийг хасахын тулд хэрэглэдэг дээрх үндэслэл, журмыг цагдан хоригдсон хугацаанд аваагүй цалин хөлсний хэмжээг тодорхойлох практик болгон тогтоосон нь хууль хэрэглээний зөрүүтэй ойлголт үүсгэжээ. Энэ талаар тусгайлсан зохицуулалт, үнэлэх аргачлал байхгүй тул өмнө үйлчилж байсан дээрх Эрүүгийн хуулийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэж цагдан хоригдсон хоногийн нөхөн олговор болон олох ёстой байсан орлогыг хооронд нь ялгалгүйгээр нэгтгэн шийдвэрлэж байгаа нь буруу жишиг гэж үзэхээр байна.

**Тохиолдол 6.**

Э нь ...аймгийн ... сумын хүн эмнэлэгт их эмч, эмнэлгийн эрхлэгчээр ажиллаж байх үедээ 2010 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Д-д эмнэлгийн тусламжийг зохих ёсоор үзүүлээгүйн улмаас өвчтөн нас барсан эрүүгийн хэрэгт 2011 оны 5 дугаар сараас 2013 оны 2 дугаар сар хүртэл буюу хоёр жил орчим хугацаанд яллагдагчаар татагдан шалгагдсан. Улмаар Сум дундын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдан хоригдож, Эрүүгийн хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан хэрэгт гэм буруутайд тооцогдон, эмчлэх эрхээ хоёр жил зургаан сарын хугацаагаар хасуулж, хоёр жил зургаан сарын хорих ялаар шийтгүүлсэн. Уг хэргийг хяналтын шатны шүүхийн 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 576 дугаар тогтоолоор тус хэрэгт нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан бөгөөд прокуророос яллагдагчийн үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

## Тохиолдол 6-гийн үргэлжлэл

Э-гийн гаргасан мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанд холбогдох 120.0 сая төгрөгийн үнийн дүнтэй нэхэмжлэлийг шүүхээс шийдвэрлэхдээ “Э-гийн цагдан хоригдсон 61 хоногийг түүний цагдан хоригдож байсан үеийн буюу 2011 онд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140,400 төгрөгтэй уялдуулан (61 хоног × 140 400) нийт 8,564,400 төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулж, 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2013 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх ажлын 307 хоногийг 2011 оны 9, 10, 11 дүгээр сарын дундаж цалин 653.021 (704,449 + 582,049 + 672,515 = 1,959,063/3 = 653,021) төгрөгөөр тооцон, нэхэмжлэгчийн аваагүй дундаж цалин 9,324,511 төгрөгийг (653,021/21.5 = 30,373 × 307 хоног) улсын төсвөөс нөхөн олгох үндэслэлтэй байхаас гадна мөн дээрх хугацааны Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцон дэвтэрт нөхөн бичилт хийхийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт даалгах нь зүйтэй. Дээрх үндэслэлээр Засгийн газрын нөөц сангаас нийт 39,844,711 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгон, Нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэж, үлдэх 80,358,337 төгрөгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэжээ.

Энэ нь өмнөх дөрөв дэх тохиолдолтой ижил шийдвэр атал яагаад ингэж зөрүүтэй тооцож үнэлсэн нь ойлгомжгүй, хууль зүйн үндэслэлгүй байна.

Тус хэрэгт цагдан хоригдсон хоногийн хохирол, нөхөн төлбөрийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, ажилгүй байсан хугацааны олох ёстой байсан орлогыг түүний ажиллаж байсан сарын цалингийн дунджаар, мөн тус хугацааны нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийх зэргээр хохирол нөхөн төлүүлжээ. Энэ тохиолдолд цагдан хоригдсон хоногийн нөхөн төлбөрийг ЭХХШТХ-ийн 45.3 дугаар зүйлд заасан аль хохиролд хамаарахыг тодорхойлоогүй ба энэ жишгээр шийдвэрлэсэн 11 иргэний хэрэг байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь сэтгэл санаанд учирсан хохирлын нөхөн төлбөр эсхүл олох ёстой байсан орлого, цалин хөлсөнд хамаарах хохирол гэдгийг аль ч тохиолдолд тодорхой заагаагүй ажээ.

Шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд хууль бусаар мөрдөн шалгагдсан буюу эрүүгийн хэрэг үүсгэгдэж яллагдагчаар татсанаас хойш тухайн хэргийг

хэрэгсэхгүй болгох хүртэл хугацааны эсхүл зөвхөн цагдан хоригдсон хугацаанд олох ёстой байсан орлого, цалин хөлсийг олгож хуулийг илт ялгаатай тайлбарлаж хэрэглэсэн шийдвэрүүд байна. Иргэний хуульд заасан хэмжээ хязгаарын хүрээнд талуудын гаргаж өгсөн нотлох баримтын хэмжээнд иргэний нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн ч хууль хэрэглээний ялгаатай байдал нь эцэслэн шийдвэрлэх ёстой асуудал гэж үзэж байна.

### **Тохиолдол 7.**

Бусдын биед хүнд гэмтэл санаатай учруулсан О-г 2016 онд Улсын Дээд Шүүхээс аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж үзэн цагаатгасан ба энэ хугацаанд 166 хоног цагдан хоригдсон. Нэхэмжлэгч "...хоригдсон хугацааг Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт заасан "... цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэнцүүлж тооцно" гэж заасныг үндэслэн 192,000 төгрөгөөр нэг хоногийг тооцож нийт 31,872,000 төгрөг нэхэмжилснийг шүүхээс үндэслэлгүй гэж үзэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн сарын ажлын 21.5 өдөрт хуваан тооцож (192,000 төгрөг: 21.5 = 8,930 төгрөг. 8,930 төгрөг × 166 хоног = 1,482,380 төгрөг) 1,482,980 төгрөгөөр хохирлыг тогтоосон.

### **Тохиолдол 8.**

Нэхэмжлэгч А нь хууль бусаар цагдан хоригдсон 42 хоногийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 8,004,000 төгрөг, ...2,6 жил ажил хөдөлмөр эрхлээгүй 5,760,000 төгрөг ...нэхэмжилсэн. Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагаас баримтаар тогтоогдсон 42 хоног хоригдсон хоногийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 8,064,000 төгрөг, ...2 жил 6 сар ажил хөдөлмөр эрхлээгүй тул хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 5,700,000 төгрөг ...тус тус гаргуулахаар ...шийдвэрлэжээ.

Дээрх хоёр ялгаатай шүүхийн шийдвэрээс үзэхэд эхний хэрэгт цагдан хоригдсон нэг хоногт олгох нөхөн төлбөрийг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг өдрөөр, нөгөө хэрэгт нь нэг сараар тооцсон нь илэрхий шударга бус шийдвэр байна.




Энэ төрлийн иргэний нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн 81 шийдвэрийн 62 хэргийн нэхэмжлэгч цагдан хоригдсон байна. Нэхэмжлэгчдийн цагдан хоригдсон хугацааг авч үзвэл гурваас 307 хүртэлх хоног байх ба цагдан хоригдсон нэг өдрийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр эсхүл нэг өдөр (21,5 хоногт хувааж)-т шилжүүлэн бодох журмаар тооцож хохирлыг нөхөн төлөх шийдвэр гаргажээ. Мөн цөөн тохиолдолд нэхэмжлэгч цалин хөлс авч байснаа нотлох буюу нийгмийн даатгалаа нотлох баримтаар гаргаж өгсөн тохиолдолд тухайн үед авч байсан гурван сарын цалингийн дундаж орлогоор хөдөлмөрийн хөлсний мөнгөн дүнг тогтоож цагдан хоригдсон хоногт үржүүлэн олгожээ. Ийнхүү Иргэний хэргийн шүүхийн практикт хууль бусаар мөрдөн шалгагдсан болон цагдан хоригдсон хоногийг тооцон хохирол тогтоож, нөхөн төлүүлж буй практик харилцан адилгүй, ялгамжтай байгаа нь тэгш байдал, шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна.

Монгол Улсад үйлдэгддэг нийт гэмт хэргийн 75 орчим хувийг эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс үйлддэг тул гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон хүний тоонд ч мөн энэ үзүүлэлт ижилхэн хамааралтай байдаг. Тиймээс олох байсан орлого, цалин хөлсийг тооцоход хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ жишиг болоод байгаа нь үүнтэй холбоотой. ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт 2020 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр хохирол нэхэмжлэх эрх үүсэх боломж, тоон харьцаанд нөлөөлөөгүй байна.

*Б) Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг хохиролд тооцож үнэлсэн байдал (ЭХХШтХ-ийн 45.3 дугаар зүйлийн 1.6 дахь заалт)*

Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг хангаж шийдвэрлэсэн 79 хэргийн хувьд 300,000 төгрөгөөс 35,000,000 төгрөгийн хооронд байх ба иргэний хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ. Зарим иргэний хэрэгт өмгөөлөл болон хууль зүйн туслалцаа авахад төлсөн мөнгөн дүнг нотолж чадаагүйгээс анх нэхэмжилснээс нь бууруулж үнэлсэн 12 тохиолдол, нотлох баримт байхгүй гэсэн үндэслэлээр дээрх нэхэмжлэлийг хангаагүй хоёр тохиолдол байна.

График 7. Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг шийдвэрлэсэн байдал

**Тохиолдол 9.**

Нэхэмжлэгч Б.М нь Ерөнхий сайдын зөвлөх С.Гансүх нарын хэрэгт холбогдон 2014 оны 4 дүгээр сарын 28-наас эхлэн хоёр жилийн хугацаанд шалгагдаж, зургаан сар цагдан хоригдож, хоёр удаа ял шийтгүүлсэн. Б.М нь цагдан хоригдсон хугацааны нөхөн төлбөрт 38,976,000, авах ёстой байсан цалин 33,600,000, эмчилгээний зардалд 2,000,000, сургуульд сурч байсан бөгөөд төлбөрөө төлсөн байсан тул 5,595,000, өмгөөллийн хөлс 35,000,000, сэтгэл санааны хохиролд 100,000,000 төгрөг тус тус, нийт 214,991,000 төгрөгийг нэхэмжилжээ. Тус иргэний хэрэгт өмгөөллийн хөлсөнд нэхэмжилсэн 35,000,000 төгрөгийг хангаж шийдвэрлэсэн.<sup>22</sup>

<sup>22</sup> Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.10.27-ны 184/ШШ2016/01282 тоот шийдвэр.

**Тохиолдол 10.**

Нэхэмжлэгч Б нь бусдын нэр хүндэд халдсан гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110 дугаар зүйлийн 110.1-д зааснаар яллагдаж, хоёр жил мөрдөн шалгагдсан. Анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгч Б-г гэм буруутайд тооцсон боловч хяналтын шатны шүүх гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан. Б нь нэр хүнд болон сэтгэл санааны хохиролд 14,000,000, өмгөөллийн хөлс 1,000,000, бусад зардал 3,500,000, цалингийн нөхөн олговор 7,783,758 төгрөг тус тус, нийт 26,283,758 төгрөг нэхэмжилсэн бөгөөд шүүх сэтгэл санааны хохиролд 10,000,000 сая төгрөг, хууль зүйн туслалцааны хөлс болох 1,000,000 төгрөгийг хохиролд тооцож шийдвэрлэжээ.

**Тохиолдол 11.**

Нэхэмжлэгч А нь хууль бусаар цагдан хоригдсон 42 хоногийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 8,004,000, өмгөөлөгчийн зардал 3,000,000, 2,6 жил ажил хөдөлмөр эрхлээгүй 5,760,000, сэтгэл санааны хохиролд 30,000,000 төгрөг тус тус, нийт 46,824,000 төгрөгийг төрөөс нэхэмжилсэн. Шүүх нэхэмжлэлийн шаардлагаас баримтаар тогтоогдсон хоригдсон хугацаа болох 42 хоногийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192,000 төгрөгөөр тооцож 8,064,000, өмгөөлөгчийн зардалд 3,000,000 төгрөг, 2 жил 6 сар ажил хөдөлмөр эрхлээгүй тул хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцож 5,700,000, сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг тус тус, нийт 23,824,000 төгрөгийг хохиролд тооцож шийдвэрлэсэн.

Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг хохиролд тооцож, үнэлэхэд ямар нэг хууль хэрэглээний зөрүү, эрх зүйн маргаан байхгүй бөгөөд сэтгэл санааны хохирол, ажилгүй байсан хугацааны цалин хөлс, олох ёстой байсан орлого зэрэг хохиролтой хамтатган мөнгөн дүнгээр үнэлж хэвшжээ. Судалсан нийт хэргээс хууль зүйн туслалцаа авсан хөлсийг тооцохдоо өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэрээг баримтлан шийдсэн 6, өмгөөлөгчид төлбөр төлсөн

баримтыг үндэслэн шийдсэн 4 тохиолдол байсан. Зарим шүүх нэхэмжлэгчээс тодорхой үнийн дүнтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэрээг дараа нь нөхөн хийх боломжтой, бодит бус гэж үзэж зөвхөн төлбөр төлсөн баримтыг үнэлэн шийдсэн 1 тохиолдол байна. Энэ нь шүүхээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ хууль зүйн туслалцаа авсан хөлсийг тогтоохдоо зөрүүтэй арга хэрэглэснийг харуулж байна.

УЕПГ-аас 2019 онд хийсэн судалгааны дүнгээс<sup>23</sup> үзвэл нийт яллагдагчийн 40 орчим хувь нь хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахгүйгээр хэргээ шийдүүлдэг гэсэн дүгнэлт хийсэн ба ЭХХШТХ-д 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд дээрх журмаар нэхэмжлэх эрх үүсэх тоон харьцаанд нөлөөлөөгүй байна.

#### *В) Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг шийдвэрлэсэн байдал (ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйл)*

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн судалсан Иргэний хэргийн шүүхийн нийт 41 шийдвэрт сэтгэл санааны хохирлыг нэхэмжилсэн байх бөгөөд үүнээс 22 хэрэгт сэтгэл санааны хохирлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд заасныг үндэслэж, мөнгөн дүнгээр хохирлыг үнэлж, гаргуулахаар шийдвэрлэжээ. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан, тус хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй учир сэтгэл санааны хохирлыг гаргуулах боломжгүй гэж тайлбарлаж шийдвэрлэсэн 19 тохиолдол байх ба ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйлийг “тусгайлсан зохицуулалт” гэж үзээгүй байна.

Өөрөөр хэлбэл, шат шатны шүүхээс шийдвэртээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйл, 45.4 дүгээр зүйлд “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрх үүссэн гэж үзсэн атлаа тухайн хохирлыг нөхөн төлүүлэх нарийвчилсан зохицуулалт байхгүй

<sup>23</sup> “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт”, УЕПГ, Сургалт судалгааны төв (тухайн үеийн нэршлээр).

гэх зөрчилтэй хууль зүйн дүгнэлт хийжээ. Мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасан "...хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй" гэсэн нь мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр төлүүлэх "тусгайлан заасан тохиолдол" гэж шууд дүгнэх боломжгүй гэж шийдвэрлэжээ.

Иргэний хэргийн шүүх, шүүгчийн харилцан ялгамжтай байдлаар сэтгэл санааны хохирлыг тооцон олгож байгаа, мөн зарим хэрэгт олгохгүй байгаа шалтгаан тодорхой бус байна. Сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн 41 хэргийн 22 хэрэгт сэтгэл санааны хохирлыг тооцож олгосон боловч юуг үндэслэж, хэрхэн тооцож олгосон нь тодорхойгүй байна.

### ***Тохиолдол 12.***

Иргэн У.Б-д Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар Хан-Уул дүүргийн шүүх түүнд 200,000 төгрөгийн эд хөрөнгө хураах, 10 жил 1 сар хорих ял ногдуулсан. Нийслэлийн шүүхэд давж заалдсанаар 2013 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 202 тоот магадлалаар У.Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан. 2011 оны 10 дугаар сарын 25-наас эхлэн шүүхээр цагаатгагдах хүртэл нийт 503 хоног шалгагдаж, 87 хоног цагдан хоригдсон. Нэхэмжлэгч сэтгэл санааны хохиролд 25,000,000 төгрөгийг нэхэмжилсэн бөгөөд шүүхээс онц хүнд гэмт хэрэгт хоёр жил мөрдөн шалгагдсан, 10 жил 1 сарын хорих ялаар шийтгүүлсэн, 87 хоног хоригдсон зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж түүнд учирсан сэтгэл санааны хохирлыг  $(25,000,000 \times 1/3)$  8,000,000 төгрөгөөр тооцон сэтгэл санааны үр дагаврыг арилгуулж, үлдэх 17,000,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон байна.

Дээрх хэргийн хувьд нэхэмжлэгчийн нэхэмжилсэн сэтгэл санааны хохирлын мөнгөн дүнг тооцохдоо ямар нэгэн аргачлал эсхүл жишиг харгалзаагүй бөгөөд анх нэхэмжилсэн үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг үзэмжээр тогтоожээ.

**Тохиолдол 13.**

Д.М-ийг Нийгмийн даатгалын сангаас тэтгэврийн мөнгө давхардуулан авч нийгмийн даатгалын санд 6,832,250 төгрөгийн хохирол учруулсан хэрэгт шалгаад хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. М нь сэтгэл санаа, эрүүл мэндийн хохиролд 202,219,400 төгрөг нэхэмжилсэн байна. Сум дундын иргэний шүүхийн шийдвэрээр мөрдөн шалгагдсаны улмаас сэтгэл санааны хохирлын үр дагаврыг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгийг 26 сараар үжүүлэн бодож 4,992,000 төгрөг олгосон байна.

Мөн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэрэгт шалгагдсан хугацаанд үржүүлэн мөнгөн дүнг тооцож гаргасан боловч энэ аргачлалаар бодох болсон үндсэн шалтгааныг дурдаагүй ажээ. Монгол Улсад 2017 оноос өмнө үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг ангилах, гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоох болон цагдан хоригдсон хоногийг хорих ялаар солих зэрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримталж байсан ба хөдөлмөрийн харилцааны энэ ухагдахууныг шүүхийн практикт өнөөг хүртэл сэтгэл санааны хохирлыг тооцоход хэрэглэж байгаа нь зохисгүй юм.

**Тохиолдол 14.**

1995 оны 2 дугаар сарын 6-ны өдөр уурын зууханд иргэн Б нь шатсан байдалтай олдсон хэрэгт иргэн Г-г 22 жилийн турш холбогдуулан шалгасан. Г нь 15 жил гадуурхагдан доромжлуулж сэтгэл санааны хувьд хүнд нөхцөлд байж байгаад 2011 оны 12 дугаар сарын 21-ний өдөр өвчний улмаас нас барсан. Түүний эхнэр 21 жилийн дараа тухайн хэргийг цагаатгаж шийдвэрлэсний дараагаар шүүхэд сэтгэл санааны хохиролд 500,000,000 төгрөг нэхэмжилсэн байна. Шүүхээс Г-г 77 хоног цагдан хоригдсон, 1995 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 21 жил бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээтэй байлгасан зэргийг харгалзан сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн.

**Тохиолдол 15.**

Нэхэмжлэгч О нь 2016 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр хүнийг алах гэмт хэрэгт сэжиглэгдэн 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдрөөс шүүгчийн захирамжаар баривчлагдан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт (хүнийг санаатай алах) зааснаар ял сонсож яллагдагчаар татагдан 119 хоног цагдан хоригдсон. Нэхэмжлэгч сэтгэл санаанд учирсан хохирлын үр дагаварт 10,000,000 төгрөг нэхэмжилснийг хангаж шийдвэрлэсэн байна.

Сэтгэл санааны хохирлын үр дагаврын хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж, барагдуулахаар шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн 22 шийдвэрээс долоон хэрэгт (10,000,000 төгрөгөөс дээш мөнгөн дүнгээр сэтгэл санааны хохирлын үр дагаврыг үнэлсэн эсхүл тухайн хэрэгт цагдан хоригдсон) ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасан хэм хэмжээг үндэслэж, нэхэмжилсэн үйл баримтыг үнэлэхгүйгээр нийтлэг байдлаар 10,000,000 төгрөгөөр тогтоожээ. Энэ нь тодорхой цаг хугацаанд шийдвэрлэсэн жишгийг харгалзан гаргасан шийдвэр байж болох талтай. Мөн сэтгэл санааны хохирлын мөнгөн дүнг тогтоосон үндэслэл бүхий баримт байдаггүй учир шүүгчийн дотоод итгэл үнэмшил, тухайн хэргийн өмгөөлөгчийн ур чадвар, нотлох баримт цуглуулж, бэхжүүлсэн байдал, нэхэмжлэлийн шаардлагын

хүрээнд сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж байна. Зарим тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нотлох баримт шаардахгүйгээр барагдуулж, зарим тохиолдолд заавал олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж, цагдан хоригдсон байх ёстой гэж үзэж хэргийг шийдвэрлэжээ.

**Тохиолдол 16.**

УДШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 1759 дугаартай Б.О-гийн нэхэмжлэлтэй хэрэгт "...Б.О-гийн 50,000,000 төгрөг гаргуулах шаардлага нь 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч, таслан сэргийлэх арга хэмжээтэй байснаас өөрт учирсан хохирлоо "сэтгэл санааны хохирол" гэж илэрхийлсэн байна. О-гийн шүүхэд гаргасан хүсэлтийн агуулга, хэрэгт авагдсан баримт, тайлбараас үзэхэд тэрээр хилс хэрэгт нийт 134 хоног цагдан хоригдсон, 21 жил сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байснаас сэтгэл санаа, эд хөрөнгө, нэр төрд учирсан хохирлоо гаргуулахаар шаардсан. Нэхэмжлэгч нь "...энэ хэргээс болж ажилгүй болсон, хамгийн бага хэмжээгээр тэтгэвэр тогтоолгосон, үр хүүхдээ харж хандаж, боловсрол эзэмшүүлж чадаагүй, нутаг орныхон дунд гэмт хэрэгтэн нэр зүүсэн, талийгаачийн гэр бүлийнхэн түүнтэй алуурчин гэж харьцдаг байсан, орох байх газаргүй болж хог түүж амьдарч байсан, бусдын дарамт, сүрдүүлэгт байсан..." тухай тайлбарыг шүүхэд ирүүлсэн байна. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд О-гийн дээрх тайлбарыг няцаах баримтгүй, түүнчлэн гэрч нарын мэдүүлгээр түүний эрх чөлөөнд халдаж байсан гэж үзэхээр нөхцөлүүд гарч байжээ. О-гийн холбогдсон эрүүгийн гэмт хэргийн ангилал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 86 дугаар зүйлийн 1, 200 дугаар зүйл гэх хоёр зүйл ангиар сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдаж, улмаар 21 жилийн хугацаанд сэжигтэн, яллагдагчаар тооцогдсон, түүнд авсан цагдан хорих, бусдын даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байсан хугацаа зэргийг харгалзан 50,000,000 төгрөгийг нэхэмжлэгчид олгохоор анхан шатны шүүх шийдвэрлэснийг буруутгахгүй.



Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар "...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл" гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан "...иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим"-д нийцэхгүй. Иймээс О-д холбогдуулсан эрүүгийн хэргийн зүйл, анги, тэрээр 134 хоног цагдан хоригдсон, 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т нийцнэ" гэж дүгнээд сэтгэл санааны хохирол гаргуулан шийдвэрлэжээ.

Ийнхүү иргэний хэргийн хяналтын шатны шүүхээс нэхэмжлэгчийн онцлог байдал, олон жилийн сэтгэл санааны дарамтад орж байсныг харгалзан сэтгэл санааны хохирол гаргуулан шийдвэрлэжээ. Гэвч өөр нэг шийдвэрт нэхэмжлэгч эдийн бус бус гэм хорыг нэхэмжлэх эрхтэй ч түүнийг хангахгүй гэсэн дүгнэлт хийсэн байна. Тухайлбал, УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 179 дугаартай хэрэгт "...Процессын эрх зүйг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1-д болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй" гэж шийдвэрлэжээ.

Мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах, тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй холбоотойгоор иргэний журмаар хянан шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийн цахим санд байгаа нийт 96 шүүхийн шийдвэртэй танилцаж үзэхэд дараах нөхцөл байдлууд тогтоогдлоо. Үүнд:

- Нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлээс хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг хамгийн их буюу 79 хэрэгт, хууль бусаар цагдан хоригдсон, хэрэгт шалгагдсаны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлогыг 59 хэрэгт гаргуулахаар шийдсэн байна. Өөрөөр хэлбэл, одоогийн шүүхийн практикт дээрх хоёр төрлийн хохирлыг гаргуулан шийдвэрлэх практик тогтжээ.
- Цагдан хоригдсон нэг хоногийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд тэнцүүлж олгож байгаа бол зарим тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг сард хуваан дүйцүүлэн тооцуулж олгож байна. Мөн сэтгэл санааны хохирлыг тогтсон үнийн дүнгээр биш хэрэгт шалгагдсан хугацаагаар нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр дүйцүүлж авсан тохиолдол ч байна.
- Нэхэмжлэгчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ур чадвар, нэхэмжлэлийн шаардлага, нотлох баримт цуглуулж, тооцуулах зэрэг асуудал нь Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт шууд нөлөөлжээ. Тухайлбал, нэхэмжлэгчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ур чадвар сайтай бол цагдан хоригдсон хоногийн мөнгөн дүн, олох ёстой байсан орлого, цалин хөлс, сэтгэл санааны хохирлыг өндөр мөнгөн дүнгээр тооцуулан шийдвэрлүүлдэг. Эндээс шүүх хуулийг харилцан адилгүй хэрэглэж, хохирлыг илт зөрүүтэй тогтоож байна хэмээн дүгнэж болохоор байна.

## 2.4. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ<sup>24</sup>

Эрүүгийн эрх зүйн шийтгэлийн шинжтэй уламжлалт хандлагаас татгалзаж, нөхөн сэргээх хандлагад суурилсан хувилбарыг нэвтрүүлэх санаачилга, үйл явц өрнөж байгаа билээ. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хохирол нөхөн төлүүлж чадахгүй байгаа өнөөгийн хандлагын алдаа дутагдлыг залруулахыг зорьж буй хэрэг юм. Нөгөө талаас уламжлалт хандлага нь эрүүгийн шүүхийн шударга байдалд эргэлзээ үүсгэхэд ч хүргэж байгаа билээ.

<sup>24</sup> Мөрдөгч, прокурор шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах эрх зүйн зохицуулалтын талаар.

Энэ бүлэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх нь зөрчигдсөн хүний сэтгэл санааны хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх гадаад орны зохицуулалтыг ХБНГУ, ОХУ, Польш, Англи, Япон зэрэг улсын хууль тогтоомжид судалгаа хийж тойм байдлаар харуулахыг зорилоо.

Дээр дурдсан орнуудын туршлагаас үзэхэд эдийн бус гэм хорыг үнэлдэг нэгдсэн арга, аргачлалуудыг хэрэглэх замаар хохирогчид учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх тогтолцоо үйлчилдэг байна. Мөн мөнгөөр илэрхийлж, нотлоход бэрхшээлтэй эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах талаар эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд нийтийн эрх зүйн бүлд багтах орнуудад эдийн бус гэм хор болон түүнийг нөхөн төлөх асуудлыг гэрээний бус үүргийн эрх зүй (*Tort law*)-гээр зохицуулдаг ажээ. Эрх зүйн бүлийн онцлогоос шалтгаалан эрх зүйн зохицуулалтын эх сурвалж нь шүүхийн прецедент болон хууль тогтоох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль, хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт зэргээс бүрдэж байна.

#### 2.4.1. Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)

Хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон, ял оногдуулсантай холбоотой гэм хорыг барагдуулах асуудлыг БНПУ-ын Эрүүгийн процессын хуулийн 58 дугаар бүлэг буюу 552-559 дүгээр зүйлээр зохицуулсан.<sup>25</sup> Тухайлбал, тус хуулийн 552.4-т “Иргэнийг хууль бусаар баривчилсан, цагдан хорьсны улмаас учирсан эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлнө” гэсэн заалтын хүрээнд хохирол, хор уршгийг нөхөн төлүүлдэг. Эрх нь зөрчигдсөн субъектээс гомдол гаргах хугацааны хувьд ЭБШХ-ийн 555 дахь зүйлд “Гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлтийг хууль бусаар цагдан хоригдсон тохиолдолд тухайн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гарсан өдрөөс нэг жилийн хугацаанд; баривчлагдсан тохиолдолд суллагдсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд гаргана” хэмээн хуульчилжээ.

<sup>25</sup> Code of Criminal Procedure (1997). [http://www.legislationline.org/download/id/4172/file/Polish%20CPC%201997\\_am%202003\\_en.pdf](http://www.legislationline.org/download/id/4172/file/Polish%20CPC%201997_am%202003_en.pdf)

БНПУ-ын Дээд шүүхийн тайлбарт “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ (хилсээр хоригдсон хоног тутамд ногдох)-г тогтооход дараах шалгуур үзүүлэлтүүдийг баримтална гэжээ. Үүнд:

1. Хохирол нь нөхөн төлүүлэх шинжтэй бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлэгдэхүйц байх;
2. Нөхөн төлбөр нь нийгмийн тухайн цаг үеийн өмчийн харилцаанд нийцсэн байх;
3. Нөхөн төлбөрийн хэмжээ нь хэт их, хэт бага байж болохгүй;
4. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн нөхцөл байдлыг цогцоор нь, бүхлээр нь авч үзэх шаардлагатай, тухайлбал, сэтгэл санааны зовуурь шаналал, үргэлжилсэн хугацаа, хэвийн байдлаа алдсан шинж төлөв гэх зэрэг болно.

#### 2.4.2. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)

Тус улсад олон нийтэд дуулиан дагуулсан хууль бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан гэм хорыг шийдвэрлэсэн хэд хэдэн шүүхийн шийдвэрээс<sup>26</sup> улбаалан Эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх комисс байгуулсан байна.<sup>27</sup> Уг комиссын үйл ажиллагааны дүрэмд зааснаар Эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх комиссын гишүүдийн гуравны хоёр нь энгийн иргэн, гуравны нэг нь хуульч, дор хаяж гуравны хоёр нь эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг тавьжээ.<sup>28</sup> Эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх комиссын бүрэн эрх нь эрүүгийн процессын явцад эрх нь зөрчигдсөн субъектийн гомдлыг хянан хэлэлцэх, шийтгэх тогтоол, магадлал, тогтоолыг хэвээр үлдээхгүй байх бодит магадлалтай тохиолдолд хэргийг давж заалдах шатны шүүхэд хянуулахаар шилжүүлдэг.<sup>29</sup>

<sup>26</sup> Laurie Elks, Righting miscarriages of justice? Ten years of the criminal cases review commission, 13 (2008), David Horan, *The Innocence Commission: An Independent Review Board for Wrongful Convictions*, 20 N. ILL. U. L. Rev. 91, 124-25 (2000), Innocence Project: Innocence Project Case Files, <http://www.innocenceproject.org/know/>

<sup>27</sup> The Royal Commission on Criminal Justice. *Report of the Royal Commission on Criminal Justice* (Gr. Brit.), 1993, Cm. 2263 (Viscount Runciman of Doxford, chairman).

<sup>28</sup> Frank Belloni, Jacqueline Hodgson, *Criminal Justice*, 185, (2000).

<sup>29</sup> Эрүүгийн хэрэгт давж заалдах хууль (Criminal Appeal Act), 1995, с.16, §13(1)(a).

Дээр дурдсан комиссын хэргийг хянан шийдвэрлэх шийдвэр нь “хэрэг хянан шийдвэрлэх үеэр илрээгүй нотлох баримт” эсвэл “онцгой нөхцөл байдал”-д үндэслэсэн байх ёстой. “Онцгой нөхцөл байдал” гэсэн заалтад шүүх хуралдааны үеэр нотлох баримт илрээгүй эсвэл нотлох баримт байсан боловч тодорхой шалтгааны улмаас ашиглаагүй, тухайлбал, өмгөөлөгчийн мэргэжлийн алдаа, үндэслэлгүй, илт хууль бус шийдвэр гаргасан эсхүл яллагдагчийг цагаатгах нотлох баримтыг үнэлээгүй зэрэг тохиолдлыг багтаадаг.<sup>30</sup> Эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх комисс нь зөвхөн Эрүүгийн хэргийн шүүх эцэслэн шийдвэрлэсэн хэргийг хянан хэлэлцдэг ажээ.

Комисс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хохирогч болсон гэх иргэний гомдлоор хянан шалгах ажиллагаа явуулдаг.<sup>31</sup> Хэдийгээр хохирсон хүн хууль зүйн туслалцаа авах эрхтэй боловч эрх ашгийг төрөөс хангадаг тул нэхэмжлэгчдийн ихэнх нь өмгөөлөгч авдаггүй байна.<sup>32</sup> Комисс хууль бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэлийн хүрээнд бие даасан өргөн цар хүрээтэй мөрдлөг, шалгалт хийх,<sup>33</sup> энэ чиглэлээр олон нийтэд мэдээлэх, эрх зүйн мэдлэг олгох зэрэг үйл ажиллагаа явуулдаг.<sup>34</sup>

Комиссын хяналтын үйл явц нь гурван үе шаттай.<sup>35</sup> Эхний үе шатанд өргөдлийг шалгаж, нэхэмжлэх эрх үүссэн, үндэслэл бий болсон эсэхийг шалгана.<sup>36</sup> Хэрэв тухайн хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй бол хүлээн авахаас татгалздаг.<sup>37</sup> Хоёр дахь шатанд хэрэг хянан шалгах менежер комиссын

<sup>30</sup> Frank Belloni, Jacqueline Hodgson, *Criminal Justice*, 147 (2000).

<sup>31</sup> Lissa Griffin, *The Correction of Wrongful Convictions: A Comparative Perspective*, 16 Am.U.Int’L L.Rev., 1278(2001).

<sup>32</sup> Criminal cases review comm’n, *Annual report 1998-99*, (нэхэмжлэгчдийн 80 хувь нь өмгөөлөгчөөр төлөөлүүлээгүй гэх үзүүлэлттэй).

<sup>33</sup> Lissa Griffin, *The Correction of Wrongful Convictions: A Comparative Perspective*, 16 Am.U.Int’L L.Rev., 1278(2001).

<sup>34</sup> Kate Malleson, *The Criminal Cases Review Commission: How Will It Work?*, 1995, Crim.L.R. 929, 932.

<sup>35</sup> Lissa Griffin, *The Correction of Wrongful Convictions: A Comparative Perspective*, 16 Am.U.Int’L L.Rev., 1278-1279 (2001).

<sup>36</sup> Lissa Griffin, *The Correction of Wrongful Convictions: A Comparative Perspective*, 16 Am.U.Int’L L.Rev., 1278 (2001).

<sup>37</sup> Annabelle James et al., *The Criminal Cases Review Commission: Economy, Effectiveness and Justice*, 2000, Crim.L.R. 142.

гишүүнд хэргийг хуваарилах ба комиссын гишүүн шалгалт хийх үндэслэлтэй гэж үзвэл мөрдөгч томилуулна.<sup>38</sup> Энэ хүрээнд комисс бие даасан мөрдлөг хийх, инженер, шүүх эмнэлэг, сэтгэцийн мэргэжилтнүүд томилуулах эрхтэй ажээ.<sup>39</sup> Гурав дахь шатанд хэрэг хянан шийдвэрлэх явцад хүний эрх зөрчсөн, хууль бус гэж үзэх үндэслэл байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлт гарган шүүхээр шийдвэр гаргуулахаар шилжүүлдэг.<sup>40</sup>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн үүргийн хүрээнд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын 1988 оны Эрүүгийн процессын хуульд шүүн таслах ажиллагааны алдааны улмаас хохирол учирсан этгээдэд нөхөн төлбөр олгох зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 133 дугаар зүйлийн 3 дугаар заалтаар нэмж тусгажээ.<sup>41</sup>

Эрүүгийн процессын хуулийн 133 дугаар зүйлд эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн бөгөөд оногдуулсан ялыг хүчингүй болгосон эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан бол хохирсон этгээд шүүхийн шийдвэрээр нөхөн төлбөр авах эрх үүсэхээр заасан байна. Мөн уг зүйлд дээрх үндэслэлээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагад гомдол гаргасан бол нөхөн төлбөр авах эрх үүсэхээр заажээ.

Мөн тус улсын Эрүүгийн процессын хуулийн 109.3 (k) дугаар зүйлд хууль бусаар хоригдсоны улмаас учирсан хохиролд нөхөн төлбөр олгохоор зааж, Эрүүгийн процессын хуульд заасан журмын дагуу төлүүлэхээр заасан байна. Түүнчлэн “Гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хууль”-д гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээг 500,000 фунт стерлинг байхаар тогтоожээ.

<sup>38</sup> Lissa Griffin, *The Correction of Wrongful Convictions: A Comparative Perspective*, 16 Am.U.Int’L L.Rev., 1278-1279 (2001).

<sup>39</sup> R v. Mattan (C.A. 1998.03.05), Grania Langdon-Down, Law: Justice Will be Done, The indep. (London), 1998.03.30. <http://www.independent.co.uk/life-style/law-justice-will-be-done-1153461.html>

<sup>40</sup> Annabelle James et al., *The Criminal Cases Review Commission: Economy, Effectiveness and Justice*, 2000, Crim.L.R. 145.

<sup>41</sup> Criminal justice act (1988) <https://www.legislation.gov.uk/ukpga/1988/33/section/133>

### 2.4.3. Япон Улс

Япон Улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлд “Баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн хүн гэм буруугүй болох нь тогтоогдож, цагаадсан тохиолдолд хуулийн дагуу нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй”<sup>42</sup> хэмээн тусгажээ. Үүний дагуу Эрүүгийн хэргийн нөхөн төлбөрийн хуулиар<sup>43</sup> энэхүү харилцааг нарийвчлан зохицуулсан ба уг хуулийн 4 дүгээр зүйлд нөхөн олговрын хэмжээг шүүхээс тогтоохоор заажээ. Шүүх уг этгээд хоригдсон учир шалтгаан, хоригдсон хугацаа, түүнд учирсан эд хөрөнгө, бие махбод болон сэтгэл санааны хохирол, цагдаа болон хэрэг хянан шийдвэрлэх байгууллагын хайхрамжгүй үйлдэл зэргийг хянан үздэг. Нөхөн олговрын хамгийн бага түвшин өдрийн 1000 иен буюу 9.08 ам.доллар байх бол дээд хэмжээ нь 12,500 иен буюу 113.51 ам.доллар байна. Мөн тус улсын Нөхөн олговрын тухай хуулиар<sup>44</sup> нөхөн олговор авах шийдвэр гаргуулахын тулд төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа хууль бусаар хохирол учруулсан болохыг нотолж тогтоосон байхыг шаарддаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хууль (刑事補償法<sup>45</sup>) 1950 онд батлагджээ.

Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хуулийн (刑事補償法) 1-р зүйл.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу ердийн журмаар, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас болон тусгай хяналтын шатны шүүхэд гомдол гаргах ажиллагааны дагуу шүүхийн шийдвэрээр

<sup>42</sup> The Constitution of Japan (1946) [https://japan.kantei.go.jp/constitution\\_and\\_government\\_of\\_japan/constitution\\_e.html](https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html)

<sup>43</sup> Criminal compensation act (1950) <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=440&vm=2&re=02>

<sup>44</sup> Н.Норовсамбуу, Ж.Содномдаржаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ. Нээлттэй Нийгэм Форум (2021), State redress act (1947) <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1933&vm=2&re=02>

<sup>45</sup> 刑事補償法（昭和二十五年法律第一号）施行日： 令和二年四月一日 最終更新： 平成二十九年六月二日公布（平成二十九年法律第四十五号）改正 [https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=325AC0000000001](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=325AC0000000001)

цагаатгагдсан этгээд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Насанд хүрээгүй этгээдийн хууль, Эдийн засгийн судалгааны агентлагийн хуулийн дагуу баривчлагдсан, цагдан хоригдсоны улмаас учирсан хохирлоо улсаас нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхийг сэргээснээр дээд шатны шүүхэд хандсан, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас болон тусгай хяналтын шатны шүүхэд гомдол гаргах ажиллагааны дагуу шүүхийн шийдвэрээр цагаатгагдсан этгээд нь өмнөх шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлсэн ялын улмаас хоригдсон тохиолдолд улсаас хохирол нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 484-486 дугаар зүйлийн хүрээнд баривчлагдсан болон тус хуулийн 481-р зүйлийн 2 дахь заалтын дагуу саатуулагдсан тохиолдолд нөхөн олговор авах эрх үүсэхээр зохицуулсан. Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хуулийн дагуу хохирол шаардах эрх үүсэхэд дараах хоёр урьдчилсан нөхцөл хангагдсан байх ёстой. Нэгдүгээрт, шүүхээс цагаатгасан шийдвэр гарсан байх, хоёрдугаарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баривчлагдсан, хоригдсон байх эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу ял эдэлсэн байх юм.<sup>46</sup>

Түүнчлэн сэжигтэн нь саатуулагдаж, баривчлагдсан, цагдан хоригдсон боловч прокурорын зүгээс хэрэг үүсгэхгүй татгалзаж шийдвэрлэсэн тохиолдолд нэхэмжлэх эрх үүсэхгүй боловч Хууль зүйн яамнаас баталсан “Сэжигтний хохирлыг нөхөн төлөх журам”-ын дагуу хохирол шаардах эрхтэй. Уг журмын 2-р зүйлд “Прокурор нь гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг яллагдагчаар татаж хэрэг үүсгээгүй тохиолдолд тухайн этгээд гэмт хэрэг үйлдээгүй гэх хангалттай шалтгаан байгаа бол баривчлагдсан, цагдан хоригдсоны хохирлыг нөхөн төлнө”<sup>47</sup> гэж заажээ.

<sup>46</sup> [http://hakusyo1.moj.go.jp/jp/1/nfm/n\\_1\\_2\\_2\\_1\\_5\\_6.html](http://hakusyo1.moj.go.jp/jp/1/nfm/n_1_2_2_1_5_6.html)

<sup>47</sup> 被疑者補償規程（法務省訓令）<http://www.kensatsu.go.jp/content/000127550.pdf>



#### 2.4.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуульд *Wiederaufnahme* (онцгой журмаар давж заалдах, хэргийг дахин хянан шийдвэрлүүлэх гомдол)-ын журмыг нарийвчлан тусгасан. *Wiederaufnahme*-ын журмаар хянан хэлэлцэж гарсан шийдвэрт давж заалдах боломжгүй.<sup>48</sup> Онцгой журмаар давж заалдахдаа өмнөх шатны шийдвэр гаргасан шүүхтэй ижил мужийн шүүхэд гомдол гаргах ёстой байдаг. Шүүгдэгч хэргээ хүлээсэн тохиолдолд яллах тал онцгой журмаар давж заалддаг. Шүүгдэгч дараах үндэслэлээр давж заалдах боломжтой. Үүнд:

1. Хуурамч баримт бичиг ашиглан хорих ял оноосон;
2. Гэрч нь шүүгдэгчийн эсрэг хуурамч мэдүүлэг өгсөн;
3. Хэргийг шүүх бүрэлдэхүүнд багтсан шүүгч албан үүргээ зөрчсөний улмаас ял хүлээсэн;
4. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг үндэслэсэн Иргэний хэргийн шүүхийн шийдвэр хүчингүй болсон;
5. Шүүгдэгчид давуу байдал олгох, хөнгөн ял оноох боломжтой шинэ нотлох баримт илэрсэн.<sup>49</sup>

Хэрэв шүүх хариуцагчийн гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг хүлээн авч, анхны шийдвэрийг хүчингүй болгох шаардлагатай эсэх дээр нотлох үндэслэлүүдийг сонсоно. Онцгой журмаар давж заалдах гомдол амжилттай болбол цагаатгах эсвэл шинэ шүүх хуралдаанаар хэлэлцэнэ. Онцгой журмаар давж заалдах гомдол гаргах үед шүүгдэгч нас барсан эсвэл гэм буруугүй нь илэрхий болж улсын яллагч яллахаас татгалзсан тохиолдолд

<sup>48</sup> Jean Pradel, Christine Van Den Wyngaert, ed. *Criminal procedure systems in the European Community*, London, Butterworths (1993), p. 161, Nigel Osner, Anne Quinn, Giles Crown, eds., *The Royal Commission on Criminal Justice: Criminal Justice Systems in Other Jurisdictions*, London, HMSO (1993), p. 102, Ira P. Robbins, *Comparative Postconviction Remedies*, Lexington (1980), p. 42.

<sup>49</sup> Jean Pradel, Christine Van Den Wyngaert, ed. *Criminal procedure systems in the European Community*, London, Butterworths (1993), p. 161, Nigel Osner, Anne Quinn, Giles Crown, eds., *The Royal Commission on Criminal Justice: Criminal Justice Systems in Other Jurisdictions*, London, HMSO (1993), p. 102, Ira P. Robbins, *Comparative Postconviction Remedies*, Lexington (1980), p.42.

шүүгдэгч цагаатгагддаг.<sup>50</sup> ХБНГУ-д онцгой журмаар давж заалдах өргөдөл гаргах нь цөөнгүй байдаг бөгөөд жилд ойролцоогоор 150-350 шүүхийн шийдвэрийг дээрх үндэслэлээр хүчингүй болгодог байна.<sup>51</sup>

Тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах тухай хуульд (1971 он) заасны дагуу эд хөрөнгийн бус хохирол болох хууль бусаар хоригдсон бол хоригдсон хоног тутамд 10 дойч марк байхаар тогтоосон. Германы Иргэний хуулийн 823 дугаар зүйлд “Санаатай эсвэл болгоомжгүйгээр хүний амь насыг хохироох, амь биед нь гэмтэл учруулсан эсвэл эрүүл мэндэд нь гэмтэл учруулсан, эрх чөлөөнд нь халдсан, өмчийн болон бусад эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй” гэж, мөн хуулийн 847 дугаар зүйлд “Бие, эрүүл мэндэд гэм хор учирсан, түүнчлэн эрх чөлөөг нь зөрчсөн тохиолдолд хохирсон этгээд учирсан эд хөрөнгийн бус шинжтэй гэм хорыг зохих хэмжээний мөнгөөр нөхөн арилгуулахаар шаардах эрхтэй” хэмээн эдийн бус гэм хорыг арилгуулах асуудлыг тусгасан.

ХБНГУ 1971 онд Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль (*Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG)*)-ийг батлан хэрэгжүүлж байна. Уг хуулийн 1-р зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хохирол учирсан этгээд нь тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон эсвэл ял оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг бусад байдлаар дуусгавар болгосон тохиолдолд төрийн сангаас хохирол шаардах эрхтэй”<sup>52</sup> гэж хуульчилжээ.

<sup>50</sup> Nigel Osner, Anne Quinn, Giles Crown, eds., *The Royal Commission on Criminal Justice: Criminal Justice Systems in Other Jurisdictions*, London, HMSO (1993), p. 102-103.

<sup>51</sup> Nigel Osner, Anne Quinn, Giles Crown, eds., *The Royal Commission on Criminal Justice: Criminal Justice Systems in Other Jurisdictions*, London, HMSO (1993), p. 102.

<sup>52</sup> Н.Норовсамбуу, Ж.Содномдаржаа, *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ*, Нээлттэй Нийгэм Форум (2021), *Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG)* <https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html>

ХБНГУ-ын дээрх хоёр хуулиас харахад хохирол шаардах эрхийн урьдчилсан нөхцөлд “хууль бус” болон “шүүгч, прокурор, мөрдөгч” гэх нэр томъёог хэрэглэлгүйгээр “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх” хэмээн томъёолсон нь энгийн ойлгомжтой бөгөөд уг тогтолцооны зорилгод нийцэж буй юм.

#### 2.4.5. Оросын Холбооны Улс (ОХУ)

Тус улсын Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус эрх эсхүл түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна гэжээ.<sup>53</sup> Мөн хуулийн 1100 дугаар зүйлд “дараах тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэм хор учруулагчийн гэм буруугаас үл хамааран нөхөн төлнө” гэж заасан.

- Аюул ихтэй зүйлийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол;
- Иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар оногдуулснаас учирсан хохирол;
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол;
- Хуульд заасан бусад тохиолдол.

ОХУ-ын Иргэний хуулийн 1101 дүгээр зүйлд зааснаар сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх ба сэтгэл санааны хохирлыг хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын шинж чанар, хэрэв гэм буруу нь гэм хорыг нөхөн төлөх үндэслэл болж байгаа тохиолдолд гэм буруутай этгээдийн гэм буруугийн зэргийг үл харгалзан шүүх тогтоох ба гэм хорын хэмжээг тодорхойлохдоо ухаалаг байдал ба шударга ёсны шаардлагыг тооцон үзэх ёстой ажээ. Мөн биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын шинж чанарыг тогтоохдоо сэтгэл санааны

<sup>53</sup> Гражданский кодекс, РФ. [http://kodeks.systems.ru/gk\\_rf/gk\\_glava8/gk\\_st151.html](http://kodeks.systems.ru/gk_rf/gk_glava8/gk_st151.html)

хохирол учруулсан тухайн нөхцөл байдлын үйл баримт, хохирогчийн хувийн онцлогийг харгалзан шүүх үнэлдэг.

**ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тайлбар.** Сэтгэл санааны хохирол гэдэгт иргэний төрөхөөс эхлэн хуульд заасан эдийн бус баялагт амьдрал, эрүүл мэнд, хувийн үнэлэмж (достоинство), ажил хэргийн нэр хүнд, хувийн халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, үйлдэл (эс үйлдэхүй)-ээр учруулсан биеийн ба сэтгэл санааны зовлон шаналал, иргэний хувийн эдийн бус эрх (нэр төрөө ашиглах эрх, зохиогчийн эрх болон оюуны бусад үйл ажиллагааны үр дүнд хуулийн дагуу бий болсон эрх) эсвэл эдийн эрхийг ойлгоно.<sup>54</sup> Түүнчлэн “шүүх нь хохирогчид учирсан сэтгэл санааны болон бие махбодын зовлон шаналал нь хэрхэн нотлогдож байгаа, ямар нөхцөл байдалд ямар үйлдэл (эс үйлдэхүй)-ээр учирсан, гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг, хохирогч сэтгэл санааны ба бие махбодын ямар зовлон шаналлыг даван туулсан, бусад материаллаг хэлбэрээр хэдий хэмжээнд нөхөн төлбөрийг үнэлж байгаа болон тухайн маргааныг шийдвэрлэхэд хамааралтай бусад нөхцөл байдлыг зайлшгүй нягтлан шалгах ёстой” гэж Дээд шүүхийн бүгд хурлаас тайлбарласан байна.

ОХУ-ын Иргэний хууль болон Дээд шүүхээс сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөхөөр тодорхой хэмжээгээр зохицуулалт хийж байгаа боловч бүрэн төгс гэж үзэх боломжгүй юм. Мөн ОХУ-ын хууль тогтоомжид биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын зэрэглэл, шинж чанарын тухай ойлголтыг тодорхой заагаагүй байдаг.<sup>55</sup> ОХУ-ын хууль тогтоомж, хууль хэрэглэх практикт сэтгэл санааны хохирлыг тогтоох тодорхой шалгуур, нийтлэг арга байхгүй харин түүнийг шүүх өөрийн үзэмжээрээ тодорхойлдог.<sup>56</sup>

Тус улсын зарим судлаач сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоох аргачлал боловсруулсан байх боловч түүнийг нь шүүхээс хэрэглэн

<sup>54</sup> “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай хууль тогтоомжийн хэрэглээний зарим асуудал”, ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоол, 1994.12.20, №10.

<sup>55</sup> Варпаховская Е.М., Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве, Иркутск, 2004, с.143.

<sup>56</sup> Дурдсан бүтээл, 136 дахь тал.

хэрэг маргаан шийдвэрлэсэн тохиолдол цөөн байдаг. Тухайлбал, судлаач Эрделевский сэтгэл санааны гэм хорын нөхөн төлөх хэмжээг тогтоохдоо дараах томъёог боловсруулан, ашиглахыг санал болгожээ.

$$D = d * fv * i * c * (1 - fs)$$

D-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх бодит хэмжээ;

d-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх нийт хэмжээ;

fv-гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг (энэ тохиолдолд  $0 \leq fv \leq 1$  байна);

i-хохирогчийн хувийн онцлогийн коэффициент (үржүүлэгч тоо) (энэ тохиолдолд  $0 \leq i \leq 2$  байна);

c-анхаарал татсан нөхцөл байдлыг тооцоолсон коэффициент (энэ тохиолдолд  $0 \leq c \leq 2$  байна);

fs-хохирогчийн гэм буруугийн зэрэг (энэ тохиолдолд  $0 \leq fs \leq 2$  байна).<sup>57</sup>

Судлаач дээрх томъёоны *d* тоог хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээтэй холбогдуулан авч үзсэн байна. Жишээлбэл, хүний биед хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт оногдуулах хамгийн хүнд ял нь 12 жил хорих ял бөгөөд энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 720 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байхаар тооцжээ. Энэ хөлс нь иргэний 10 жилийн дундаж цалин хөлстэй тэнцэнэ (судлаач энэхүү хэмжээг татварын хууль тогтоомжтой уялдуулан дундаж хөлс гэж тооцоолон авч үзсэн байна).<sup>58</sup>

Хууль бусаар цагдан хорих эсхүл өөр байдлаар эрх чөлөөг хязгаарлах нь хууль бусаар ял шийтгэхийн хүнд үр дагаварт орохгүй бөгөөд сэтгэл зүйн хохирол учруулсны төлөө бие даасан хариуцлага хүлээлгэнэ. ОХУ-ын Иргэний хуулийн 1100 дугаар зүйлд тухайн этгээдийг хууль бусаар буруутгаж, эрүүгийн хариуцлагад татаж, цагдан хорьсон тохиолдолд хохирол

<sup>57</sup> Эрделевский А.М., *Моральный вред и компенсация за страдания: научно-практическое пособие*, М., 1998, с.69.

<sup>58</sup> Варпаховская Е.М., *Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве*, Иркутск, 2004, с.150.

барагдуулахаар тусгасан. Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар хувийн эдийн бус эрх, бусад материаллаг бус эрх зөрчигдсөн тохиолдолд хохирол барагдуулна. Хууль бусаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамрагдсан этгээдийг нөхөн сэргээх журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 133, 139, 397, 399-ийн дагуу шийдвэрлэнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 18 дугаар бүлэг, 133 дугаар зүйлд<sup>59</sup> нөхөн сэргээх ажиллагаанд хамрагдах субъектүүдийг зааж өгсний дотор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хохирол учирсан тохиолдол хамаарч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн буруугаас үл хамааран төр бүрэн хэмжээгээр нөхөн төлөх зохицуулалттай.

---

<sup>59</sup> Уголовно-процессуальный кодекс РФ., Часть первая, Раздел 6, Глава 18, Статья 133. <http://kodeks.systems.ru/upk-rf/glava18/st133.html>

## ДҮГНЭЛТ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.2 дугаар зүйлд заасан нэхэмжлэл гаргах эрх үүссэн тохиолдолд гаргасан нэхэмжлэлийн тоо тодорхойгүй боловч энэхүү судалгааны ажлын тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд нэг жилд дунджаар (баривчлагдсан, цагдан хоригдсон, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж шийдвэрлэсэн, эрүүдэн шүүсэн нь тогтоогдсон) 400 орчим эрүүгийн хэрэг<sup>60</sup> мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагааны улмаас учирсан гэм хорыг нэхэмжлэх эрх үүсэх боломжтой байна. Гэвч Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн цахим сангаас<sup>61</sup> шүүж үзэхэд дээрх журмаар жилд дунджаар 20-25 нэхэмжлэл гаргажээ. Үүний шалтгаан нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруутай нь нотлогдоогүй, тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг хэрэгсэхгүй болгосон хэргийн яллагдагч өөрт учирсан хохирлоо нэхэмжилдэггүй, энэ талаар хуульд заасан үндэслэлийг тайлбарлаж өгдөггүй, мэдээлэлгүй байсан зэргээс болжээ. Мөн ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэг нь “хууль зөрчсөн ажиллагаа” гэх нэршил оруулснаас үүдэн эрх нь зөрчигдсэн ч тус ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан бол нэхэмжлэх эрх үүсэхгүй хэмээн ташаа ойлгож байгаатай ч холбоотой байж болох юм.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан хэдий ч тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны эрх зүйн үр дагаврыг төр хариуцан арилгах үүрэгтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн

<sup>60</sup> Тухайн онд мөрдөн байцаалт, шүүхийн шатанд гэмт хэргийн шинжгүй, үндэслэлгүйгээр баривчилсан, цагдан хорьсон, албан үүргийг түдгэлзүүлсэн, цагаатгасан, эрүүдэн шүүсэн тохиолдлын тоон үзүүлэлтийг нэг жилд хуваан үзэхэд дээрх үзүүлэлт гарч байна.

<sup>61</sup> <http://shuukh.mn/>

үр дагаврын талаар заасан. Тус заалтыг шүүх хэрэглэхдээ “энэхүү ажиллагаанд холбогдох албан тушаалтны “хууль бус үйлдэл бүхий ажиллагаа хамаарна”, “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа хамаарна” гэж ялгамжтай авч үзжээ. Шүүхийн шийдвэр ийнхүү илт ялгаатай байгаа нь ЭХХШТХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлт, шүүгчийн дотоод итгэл үнэмшил, субъектив үнэлэмжээс хамааралтай байна.

3. Судалгааны хүрээнд цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагддаг гэж дийлэнх мөрдөгч, прокурор, шүүгч нар үздэг ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн гарчигт заасан “хууль бусаар” гэдэг нь тухайн бүлэгт бүхэлд нь хамааралтай гэж ойлгож, хуулийн зүйл заалтыг хэрэглэж байгаа нь зохисгүй юм. Мөн ЭХХШТХ-д 45 дугаар бүлгийн гарчигт заасан хууль бусаар явуулсан гэх үйл баримт “эрүүдэн шүүсэн” хэргээс бусад шийдвэрт тогтоогдох боломжгүй бөгөөд төрийн болон албаны нууцтай холбоотойгоор мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах алдаа, зөрчлийн талаар мэдээлэл нууц байгаа тул энэ чиглэлээр судалж дүгнэх боломжгүй байв.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2020 онд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд тус хуулийн 45 дугаар бүлгийн гарчиг, зарим зүйл, хэсэгт оруулсан өөрчлөлт нь хүний эрхийн ухралт болсон гэж үзэж байна. Тухайлбал, ЭХХШТХ-д 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулахдаа тухайн хэрэг нь нотлогдоогүй тохиолдолд мөрдөн байцаалтын шатанд авсан бүхий л төрлийн таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдуулан хохирол нөхөн төлүүлэх эрх үүсэхээр байсныг өөрчилж шүүхээс зөвшөөрөл шаарддаг таслан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нэхэмжлэх эрх үүсэхээр зохицуулсан нь ухралт юм. Тухайлбал, үүний улмаас хязгаарлалт тогтоох буюу хилийн хориг, тодорхой газарт очихгүй байх зэрэг арга хэмжээнээс үүдэн гарсан хохирлыг нэхэмжлэх боломжгүй болсон. Зөвхөн энэ шалтгааны улмаас ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлэгт заасны дагуу нэхэмжлэл гаргах эрх үүсэх



тохиолдол тав дахин буурсан үзүүлэлт ажиглагдсан.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт зааснаар мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагаанаас болж хохирсон иргэн эдийн хохирол буюу аваагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болон эд хөрөнгийн бусад хохирлыг гаргуулах боломжтой боловч эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх тухай нарийвчлан зохицуулаагүй. Үүний улмаас иргэний журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй гэх шалтгаанаар нэхэмжлэлийн зарим хэсгийг хангах боломжгүй гэж үзсэн байхад Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэж 1 саяас 25 сая төгрөг хүртэл ялгамжтай тогтоож шийдсэн эсхүл нэг ижил хэмжээгээр буюу 10 сая төгрөгөөр тогтоож шийдсэн нь хууль хэрэглээний хувьд илт зөрүүтэй шийдвэрүүд юм. Энэ нь иргэний хууль тогтоомжийн шинэчлэлээс шууд хамаарч байна.
6. Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон хоногийн нөхөн төлбөрийг тооцохдоо ажилгүй байсан хугацааны гэм хор, олох ёстой байсан орлоготой хольж шийдэж байгаа буруу жишиг тогтсон байна. Энэ талаар тусгайлан зохицуулсан хуулийн зохицуулалт, дүрэм, журам байхгүй байгаа нь үүнд сөргөөр нөлөөлжээ. Мөн цагдан хоригдсон хоногийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажлын 21.5 хоногт хуваасан дүнгээр гэх зэргээр илт зөрүүтэй тооцжээ.
7. Нэхэмжлэгчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ур чадвар, нэхэмжлэлийн шаардлага, нотлох баримт цуглуулж, тооцуулах зэрэг асуудал нь Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлага болон өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн чадвар иргэний хэргийг ялгамжтай шийдвэрлэхэд нөлөөлсөн гэж үзлээ. Мөн энэ хэргийн нэхэмжлэгч нотлох баримтаа өөрөө цуглуулах үүрэгтэй тул хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг болон дотоод хяналт шалгалтад хамаарах зарим баримтыг олж цуглуулах боломжгүй нөхцөлд хэргээ шийдүүлж байна.

8. Шүүхийн шийдвэрээс харахад хохирсон этгээд буюу нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг хэрэгсэхгүй болгох эсхүл нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэжээ. ЭХХШТХ, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид эдийн шинжтэй буюу эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг илүүтэй зохицуулж, хохирсон амь нас, эрүүл мэндэд учирсан гэмтэл согог, хүний сэтгэл санаанд учруулсан шаналал зовуурийг үнэлэх асуудлыг орхигдуулжээ. Энэ талаар судалгаанд хамруулсан улсын хувьд төгс зохицуулалт байхгүй байгаа ч өөр өөрийн онцлогийг тусгасан хуулийн зохицуулалт үйлчилж, шүүхүүд нь илүү санаачилгатай, бүтээлчээр асуудалд ханддаг байдал ажиглагдав.
9. Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг тогтоох, нөхөн барагдуулах талаар тусгайлсан байгууллагатай (ИБУИНВУ) эсхүл Иргэний хуулиар тусгайлан зохицуулсан (ОХУ), мөн тусгайлан гаргасан нөхөн олговрын хуультай (Япон), Эрүүгийн болон Иргэний хуулийн хосолсон зохицуулалттай (Польш) зэрэг ялгаатай бүтэц, хууль эрх зүйн орчинтой байна. Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан гэм хорыг нэхэмжлэх эрх үүсэх орны хуулийн зохицуулалтад заавал хууль зөрчсөн байхыг шаардахгүйгээр тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй, гэм буруугүй нь тогтоогдсон, цагаатгасан талаар эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэр гарснаар тухайн эрх үүсэхээр зохицуулжээ. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг хууль бус байсан эсэхээс үл хамааран барагдуулах нь тус ажиллагааны тун чухал баталгаа болох бөгөөд хүний эрхэд суурилсан үзэл хандлагаас үүдэлтэй.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангахын тулд хүний зөрчигдсөн эрхийг сэргээхдээ “мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах” үүргийг тодорхой болгох. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 45 дугаар бүлгийн гарчиг болон зарим зүйл хэсэгт 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн “хууль зөрчсөн ажиллагааны улмаас” гэсэн томъёоллыг хүчингүй болгох, Иргэний хуулийн 498 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
2. Иргэний хуулийн эдийн бус гэм хорын талаар хуулийн тодорхойлолтыг дахин шинэчлэх, санаатай болон болгоомжгүй үйлдлийн гэм бурууг хэрхэн тодорхойлох, түүнийг арилгах эсвэл нөхөн төлөх аргууд (мөнгөн хэлбэрээр, нэр төдий буюу номинал хэлбэрээр гэх мэт) болон мөнгөн төлбөрийг бодож гаргах нэгдсэн аргачлал бий болгох нь хүний эрхийг хамгаалах, шударга ёсны болон тэгш эрхийн зарчимд нийцэхээр байна. Иймд хохирлын хэмжээг тогтоохын тулд түүнд харгалзах үзүүлэлт буюу шалгуур, боломж, мөн мөнгөн төлбөр төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тогтоох асуудлыг олон улсын чиг хандлага, туршлагатай харьцуулан хөгжүүлэх;
3. ЭХШШТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.6, 45.7 дахь хэсэгт шүүх, прокурор нь хүн, хуулийн этгээдэд зөрчигдсөн эрхээ сэргээх, бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлах, лавлагаа өгөх зэрэг заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, ажил дүгнэх үзүүлэлт болон хэргийн шийдвэрлэлтэд харгалзах үзүүлэлт болгож оруулах;
4. ИХХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн дагуу төрийг төлөөлөн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох прокурорын оролцоо, төрийн болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын идэвх санаачилгыг Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нэмэгдүүлэх;
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт зааснаар мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл

ажиллагаанаас учирсан хохиролд хамаарах буюу харгалзах бүх үзүүлэлтийг шинж чанараар нь нарийвчлан тогтоож, тэдгээрийг нэг бүрчлэн үнэлэх, хохирол, нөхөн төлбөрийг тооцох, түүнийг гаргуулах журмыг батлан хэрэгжүүлэх талаар эрх олгосон хэм хэмжээг тус бүлэгт нэмж тусгах;

6. Учирсан хохирлын хэмжээг тогтоох, нөхөн төлбөр тооцох, түүнийг гаргуулах талаар тусгайлан зохицуулаагүй бол хөрөнгийн үнэлгээ тогтоох журмын дагуу гаргуулах бөгөөд шаардлагатай бол шинжээч томилж тухайн хууль бус ажиллагааны улмаас алдагдсан, ашиглалтаас гарсан, эвдэрсэн, гэмтсэн, ажиллагаагүй болсон, шинж байдлаа алдсан эд зүйл, техник, тээврийн хэрэгслийн үнэлгээ, мал амьтны нөхөн төлбөрийн хэмжээг тооцох зохицуулалтыг нэмэх;
7. ЭХХШтХ-ийн хохирол, нөхөн төлбөрийн үнэлгээ хийлгэх, шинжээч томилохтой холбогдон гарсан зардлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргуулах, шийдвэрлэгдсэн зарим эрүүгийн хавтаст хэрэгт үзлэг хийх талаар зохицуулалтыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах;
8. Хуульчдын үргэлжилсэн сургалт болон хууль сахиулагчдын мэргэжлийн сургалтад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой сургалтын хөтөлбөр боловсруулж, нэгдсэн ойлголт, ур чадвар олгох.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

## Монгол хэлээр:

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ., 2017.
2. Монгол Улсын Дээд Шүүх, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV”, УБ., 2016.
3. Ё.Кают, Э.Шпанглер нар, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар”, УБ., 2010.
4. Ц.Одмаа, Нийтийн эрх зүйн бүлийн зарим улс дахь эдийн бус гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт, Хууль дээдлэх ёс, 2009, Дугаар 01.
5. Швейцарын хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, “Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилгоо, тусламж: Мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага”, УБ., 2010.
6. Б.Батсайхан, М.Дэлгэржав, Ерөнхий сэтгэл судлал, Анхны хэвлэл, УБ., 2013.
7. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011.
8. Б.Буянхишиг, “Үүргийн эрх зүй (Ерөнхий анги)”, УБ., 2013.
9. Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006.
10. Ж.Оюунтунгалаг, Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага. Хууль дээдлэх ёс, 2019, Цуврал 1 (71).
11. Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013.
12. Гүнтэр Кристиан Шварц, Манфрэд Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ., 2017.
13. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2007.
14. Б.Отгонзул, “Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011.

## Гадаад хэлээр:

1. Black's law dictionary, 542 дахь тал (7th ed. 1999).
2. Betsy J. Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L. Rev., 2605 (2015).
3. Finja Marten, The Mediating Effect of Eustress and Distress on the Relation between the Mindset Towards Stress and Health.
4. Amir Mohammad Shahsavarani, Esfandiar Azad Marz Abadi, Maryam Hakimi Kalkhoran, Stress: Facts and Theories through Literature Review, International Journal of Medical Reviews, Volume 2, Issue 2, Spring 2015.
5. Aline Drapeau, Alain Marchand and Dominic Beaulieu-Prévost, Epidemiology of Psychological Distress, 2012.
6. M.Lee Huffaker, Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama.
7. Francis X., Clinch and Jodie L., Johnson, Compensation of Emotional Distress in Montana: Distinctions between Bystanders and Direct Victims, 47 Mont. L. Rev. (1986).
8. Ulrich Magnus, "The Reform of German Tort Law", Universidad de Hamburgo.
9. Madeleine Tolani, "U.S. Punitive damages before German courts: A comparative analysis with respect to the ordre public", Annual Survey of International & Comparative Law, Vol. 17, Iss. 1, Article 9, 2011.
10. Volker Behr, "Punitive Damages in America and German Law - Tendencies towards Approximation of Apparently Irreconcilable Concepts", Chi.-Kent. L. Rev. (2003).
11. Ruben Enrique Rodriguez Samudio, Non-economic losses under Japanese law from a comparative law perspective, Hokkaido University, Doctoral thesis, 2017.

## Хууль тогтоомж, Дээд Шүүхийн тайлбар, зөвлөмж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1.
2. Иргэний хууль, 2002, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.

3. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2016, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2017, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №23.
5. Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”, Дугаар 15.







ISBN 978-9919-9742-7-5



9 789919 974275

